**ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ II-ЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН**
**ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 05 Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, сая төгрөг (Эх үүсвэр) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО НЭГ: "Эрүүл Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийгмийн эрүүл мэндийн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг зохион байгуулна. | | | | | | | |
| Зорилт 1.1: Эрүүл мэндийн сайдын тусгайлан өгсөн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. | | | | | | | |
| 1 | **БСТ 1.3.2.** “Үр хөврөлийг умайд суулгахаас өмнө генетекийн оношилгоо”-г үе шаттайгаар хөгжүүлнэ . | 110.0 (ЭМД-ын сангийн санхүүжилт, олон улсын байгууллагын санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Төлөвлөсөн арга хэмжээг 50% хэрэгжүүлсэн | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Ерөнхий захирлын 2025 оны 07 сарын 09 сарын А/36 дугаар тоот тушаалаар “Эх ургийн анагаах ухааны багийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. **Эх ургийн анагаах ухааны нэгжийг** байгуулж, багийн ахлагчаар Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал, зөвлөх эмч Ж.Оюунцэцэг, гишүүдэд Жирэмсний эмгэгийн эмчлэх тасгийн эрхлэгч Л.Цэвэлмаа, Дутуу тээлт судлалын тасгийн эрхлэгч О.Алтанзул, Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч Б.Төмөрбаатар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нярайн тасгийн эрхлэгч Ч.Батням, Удамзүйн лабораторийн эмнэлзүйн эмч Д.Урангоо, Удамзүйн лабораторийн цитогенетикч эмч Д.Орлом, Перинатологич, эх барих эмэгтэйчүүдийн эмч Ө.Отгонжаргал, Эмгэг судлалын эмч Н.Батдорж нар ажиллаж байна.<br>**Пренатологийн** эмч нарыг үе шаттайгаар сургалтад хамруулан 2024 онд Б.Лхагвасүрэн эмч төгссөн, 2025 онд Эх барих эмэгтэйчүүдийн эмч Ө.Отгонжаргал ЭХЭМҮТ-д Эх ургийн анагаах ухааны чиглэлээр суралцаж, 2026 оны 2 дугаар сард төгсөнө.<br>**Жирэмсний эрт үеийн нийлмэл илрүүлэгт** 2023 онд 82 эмэгтэй хамрагдаж, эрсдэлтэй 1, 2024 онд 156 эмэгтэй хамрагдаж, эрсдэлтэй 3, 2025 онд 215 эмэгтэй хамрагдаж, эрсдэлтэй 5 эмэгтэйг илрүүлсэн.<br>**Ургийн төрөлхийн хөгжлийн гажигийн илрүүлгээр** зүрх судасны эмгэгтэй 2023 онд 1, 2024 онд 3, 2025 онд 3, уруул тагнайн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэтэрхий 2023 онд 2, 2024 онд 2, 2025 онд 3, мэдрэлийн хөгжлийн гажиг 2023 онд 2, 2024 онд 3, 2025 онд 5, Хоол боловсруулах эмгэгийг гажиг 2024 онд 2, 2025 онд 3, Бөөр шээс дамжуулах эмгэгийн гажиг 2023 онд 1, 2024 онд 3, 2025 онд 6, Яс, булчингийн гажиг 2024 онд 1, Амьсгалын тогтолцооны эмгэг 2024 онд 1, нэг ихэс, 1 амнионтой ихэр жирэмсэнгийн ургаас урагт цус юүлэгдэх хам шинж /TTTS/ 2023 онд 2, 2024 онд 2, 2025 онд 3, бусад (лимфангиома) 2024 онд 1 оношлогдсон.<br>**ҮР ДҮН:** Ургийн оношилгоо 2023 оноос 2-3 дахин нэмэгдсэн. | |
| 2 | **БСТ 1.3.12.** Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээг нутагшуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллана. | 200.0 (ЭМД-ын сангийн санхүүжилт, олон улсын байгууллагын санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тайлан | Төлөвлөсөн арга хэмжээг 90% хэрэгжүүлсэн | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Хүүхдийн зүрх судас, судсан дотуурх мэс заслын баг 2024 оны 10 сард 1 сарын хугацаатай Энэтхэг улсын Сарводая эмнэлгийн сургалтад хамрагдсанаас хойш 2025 онд нийт 85 хүнд **ангиографийн оношилгоо, эмчилгээ** хийснээс 66 хүнд зүрхний **титэм судасны** оношилгоо, эмчилгээ, титэм судасны хүнд хэлбэрийн нарийсалтай 15 хүнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ангиопластик мэс засал буюу **стент тавих** эмчилгээг амжилттай хийв. Эмэгтэйчүүдийн тасгийн багтай хамтран умайн хоргүй **лейомиома** хавдартай 19 хүнд судас бөглөх эмчилгээ, **УГТЭ-тэй** хамтран зүрхний хэм алдагдалтай **6 хүүхдэд электрофизиологийн** оношилгоо, эмчилгээ хийснээс дөрвөн хүүхдэд хэм алдагдлыг түлэх эмчилгээ, нэг хүүхдэд хөлдөөх аргаар эмчилгээ хийсэн.<br>**Хүүхдийн зүрхний ЭХОКГ** оношилгоог 4560 хүүхдэд шинжилгээ хийж, тэдгээрээс 83 хүүхдэд төрөлхийн зүрхний гажиг илрүүлсэн. **Зүрхний хэм алдагдалтай** 22 хүүхдийг оношилж, ховдлын дээжих түгшээ (SVT)-тэй найм, WPW синдромтой зургаа, ховдлын хугацаанаас урьтаж агших хэм алдагдал (PVC)-тай зургаан хүүхдийг тус тус хяналтад авсан.<br>Төрсөн 3930 **нярайд** төрсний дараах эхний өдрүүдэд зүрхний ЭХОКГ оношилгоо хийж, төрсний дараах хяналтын тогтолцоог улам сайжруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **“Эрүүл Монгол хүн”** үндэсний хөдөлгөөний хүрээнд зургаан настай 2300 хүүхдийн ЭКГ уншиж, тэдгээрээс өөрчлөлттэй 852 хүүхдэд зүрхний ЭХО шинжилгээ хийснээр 41 хүүхдэд зүрхний төрөлхийн цоорхойг шинээр илрүүлж, 11 хүүхдийг УГТЭ-д мэс заслын эрт үеийн эмчилгээнд илгээв. **Баянхонгор аймгийн** зургаан настай 1900 хүүхдийн ЭКГ бичлэгийг уншиж, улсын хэмжээнд хүүхдийн зүрх судасны өвчлөлийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулав. **Төрөлхийн зүрхний гажигтай** 97 тохиолдлыг оношилж хяналтад авч, хүнд хэлбэрийн хавсарсан гажигтай зургаан хүүхэд мэс заслын эмчилгээнд орж эрүүлжсэн бөгөөд бусад төрөлхийн гажигтай 15 хүүхдэд мэс заслын эмчилгээ хийгдсэн.<br>Бүрэн АВ канал болон хөхрөлттэй **хавсарсан хүнд гажиг** оношлогдсон хүүхэд БНСУ-д Тетралоги Фалло оношоор амжилттай хагалгаанд орсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн 2025 оны 8-р сард **том судасны солбио байрлалтай хүнд хэлбэрийн гажигтай** нярайг төрсний 24 цагийн дотор оношилж, зүрх судасны эмч Т.Мөнхтулга аюулгүй тээвэрлэн БНХАУ-ын Хувэй эмнэлэгт хүргэж өгснөөр хүүхэд зүрхний нээлттэй хагалгаанд орж эрүүлжсэн байна.<br>**Зүрхний хэм алдагдлын** урт хугацааны хяналтын системийг сайжруулж, 2025 оны 8-р сараас 24–72 цагийн бичлэг бүхий хоёр ширхэг **холтер аппаратыг** шинээр ашиглалтад оруулсан бөгөөд 11-р сарын байдлаар нийт 60 хүүхэд, 90 насанд хүрэгчдэд холтерийн шинжилгээ хийж, шинээр таван хүүхэд болон гурван насанд хүрэгчийг хэм алдагдлын хяналтад авсан. 2025 оны 8-р сард тогтолцооны чонон ярын улмаас зүрхний үнхэлцэгт шингэн ихсэж **зүрхний тампонад** болсон хүүхдэд мэс засал, мэдээгүйжүүлэг, зүрх судасны эмч нарын баг ЭХЭМҮТ-ийн цээжний хөндийн мэс заслын эмчтэй хамтран яаралтай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **стернотоми мэс заслыг** амжилттай хийж, хүүхдийг зүрх судасны эмчийн хяналтад авч үргэлжлүүлэн эмчилж байна.<br><br>**ҮР ДҮН:** Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээ шаардлагатай тохиолдол маш цөөн (жилд 3-5 тохиолдол), тоног төхөөрөмж өндөр өртөгтэй тул УГТЭ-тэй хамтран зүрхний хэм алдагдалтай **6 хүүхдэд электрофизиологийн** оношилгоо, эмчилгээ хийснээс 4 хүүхдэд хэм алдагдлыг түлэх эмчилгээ, нэг хүүхдэд хөлдөөх аргаар эмчилгээг хийсэн. | |
| 3 | **БСТ 1.1.7.** Жирэмсний бүлгийн хяналтын жишиг өрөөг тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | 50,0 (Төслийн санхүүжилт) | Зохион байгуулсан сургалт болон оролцогчдын тоо | - | Жирэмсний бүлгийн хяналтын өрөөг тохижуулж, сургалт зохион байгуулсан байна. | **“Эрүүл монгол хүн”** үндэсний хөдөлгөөний санхүүжилтээр Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах эх, ураг нярайн өвчлөл эндэгдлийг бууруулж, эрүүл монгол хүнийг өсгөхөд чиглэсэн **"Жирэмсний бүлгийн хяналт"-**ыг хэрэгжүүлэн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, эрүүл аж төрөх ёс зүй, эрүүл мэндийн боловсролд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | онцгой анхаарч хамтран ажиллахаар олон улсын жишигт нийцсэн өрөөг тохижуулсан.<br>“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний Эрүүл эх нялхас бүлгийн хүрээнд жирэмсэн эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох “Жирэмсний бүлгийн хяналт” загвар төслийг ЭМЯ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2 хамтран хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай Монгол Улсын Ерөнхийлөгчийн **Эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх Б.Бадамцэцэг** биеэр ирж танилцсан.<br>Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулагдсан "Жирэмсний бүлгийн хяналт"-ын **сургагч багш бэлтгэх** 2 удаагийн сургалтанд ЭНЭҮТ 3 эмч, 3 эх баригч давтан хамрагдсан.<br>Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвд зохион байгуулагдсан "Жирэмсний бүлгийн хяналт" сургалтанд бүх эх баригч, жирэмсний хяналтын эмч нар, ХУД, СХД-ийн Өрхийн эрүүл мэнд төв, Нэгдсэн эмнэлгээс эмч, сувилагч нар сургалтанд хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **ҮР ДҮН:** Жирэмсний бүлгийн хяналтын 3 удаагийн сургалтанд 82 эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригчийг хамруулсан | |
| Зорилт 1.2: Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг зохион байгуулна. | | | | | | | |
| 4 | **БСТ 1.1.7, 1.1.8, 2.1.3.** Иргэдийн эрхтэн тогтолцооны эмгэг илрүүлэх урьдчилсан сэргийлэх үзлэг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 80.0 (ЭМД-ын сангийн санхүүжилт) | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоо | 2293 иргэн хамрагдсан. | 3000 үйлчлүүлэгч хамрагдаж, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | **Эрт илрүүлэг үзлэгт** 3183 хүн 68% эмэгтэй, 32% эрэгтэй хүмүүс хамрагдаж,, хоол боловсруулах замын өвчлөл зонхилж байна.<br>1) Хоол боловсруулах замын өвчлөл 1702 (45%)<br>2) Амьсгалын тогтолцооны өвчлөл 222 (7%)<br>3) Зүрх судасны тогтолцооны өвчлөл 413 (13%)<br>4) Бөөр шээс дамжуулах тогтолцооны эмгэг 541 (17%)<br>5) Бодисын солилцооны алдагдал, дотоод шүүрлийн өвчлөл 573 (18%)<br>**Урьдчилан сэргийлэх үзлэгт** “ЭКО ОРЧИН” ТҮК компани, Нийслэлийн эрүүл мэндийн газар, ХУД 21-р хорооны ахмад настангууд, ХУД-ийн хороодын ажилчид, Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгийн газар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Сайхан Төмөр” төмрийн үйлдвэр, Степп Арина ХХК, ХУД-ийн 290-р цэцэрлэг ажилчид, Баянчандмань политехник коллеж багш нар, ХУД-ийн 326 цэцэрлэгийн ажилчид, Жаргалант Сувилалын ажилчид, Угтаал эмнэлэг, Угтаал Цэцэрлэг, Угтаал ЕБС, ШШЕГ 407-р хорих анги, Прокурорын газар, Солонго хороолол, Цагаан нуур ЭМТ, Нумт гүрэн амралтын газар, Наран сумын ЗДТГ, Баянмөнх сумын сургууль, Монгол Чанар Констракшин ХХК, ШШГЕГ 401-р хорих анги, Мөнххада ХХК зэрэг 25 байгууллагын 1049 албан хаагчдыг хамруулсан.<br><br>**ҮР ДҮН:** эрт илрүүлэг үзлэгээр нойр булчирхайн архаг үрэвсэлтэй 133, архаг ходоодны үрэвсэлтэй 67, элэгний үрэвсэлт өвчин тодорхойгүй 82, гастродуоденит, тодорхойгүй 60, сувганцрын завсрын эдийн архаг нефрит тодорхойгүй 44, зүрхний хурмал дутмагшилгүй даралт ихсэлттэй 30, хоол боловсруулах эрхтний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үрэвсэл, шархлаатай 38 хүний өвчин, эмгэгийг эрт илрүүлж, зөвлөгөө өгсөн. | |
| 5 | **БСТ 2.1.5**<br><br>Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж, үзлэгт хамруулна. | 20.0 (ЭМД-ын сангийн санхүүжилт) | Хамрагдсан эрэгтэйчүүдийн тоо | 526 иргэн хамрагдсан. | 1000 үйлчлүүлэгчийг хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | **Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн** үзлэг, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо 1018 эрэгтэйд хийгдсэн.<br>• 18-30 насны 105<br>• 31-45 насны 386<br>• 46-60 насын 292<br>• 60-с дээш насны 235 эрэгтэйчүүдэд тусламж үйлчилгээг үзүүлсэн.<br>**Зөвлөх поликлиникээр** эрэгтэйчүүдэд зориулсан “Эрэгтэйчүүдийн үнэт зүйл, үлгэр дуурайлал” сэдвээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, тараах матераил бэлтгэн тарааж, Зөвлөх поликлиникт материалуудыг байршуулсан.<br><br>**ҮР ДҮН:** урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоонд **1018 эрэгтэйг** хамруулан “Эрэгтэйчүүдийн үнэт зүйл, үлгэр дуурайлал” сэдвээр эрүүл мэндийн боловсрол олгосон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | **БСТ 1.1.7**<br>Жирэмснээс хамгаалах орчин үеийн арга хэрэгслийн талаарх сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, үзлэгт хамруулна. | 10.0 (ЭМД-ын сангийн санхүүжилт) | Хамрагдсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо | 6300 иргэн хамрагдсан. | 8500 үйлчлүүлэгчийг хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | **Нөхөн үржихүйн кабинетээр** умайд ерөндөг болон бугалганы суулгацыг нийт 820 эмэгтэйд тавьж, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөв.<br>Жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн талаарх сургалт нийт 187 цаг орсон байна.<br><br>**ҮР ДҮН:** Зөвлөх поликлиникээр давтагдсан тоогоор нийт **9140 иргэдэд** нөхөн үржихүйн сургалтыг 284 цаг зохион байгуулсан. | 100% |
| 7 | **БСТ 1.2.2.**<br>6 настай хүүхдүүдийг зүрхний эмгэг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөлийг эрт илрүүлэх, хяналтын тогтолцоог бий болгоно. | 15.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | 3000 | 5000 | Баянхонгор аймгийн 26 сургуулийн 1910 хүүхэд, Дорноговь аймгийн 18 сургуулийн 1052 хүүхэд, Хан-уул дүүргийн 11 сургуулийн 3500 хүүхдэд зүрхний эмгэг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөлийг эрт илрүүлэх үзлэгийн хүрээнд хийгдсэн ЗЦБ-ийг ЭНЭҮТ-ийн хүүхдийн зүрхний эмч Т.Мөнхтулга, Т.Тэгшжаргал нар авч дүгнэн ЗЦБ-т өөрчлөлттэй 1267 хүүхдэд зүрхний ЭХОКГ оношилгоонд хамруулсан.<br><br>**ҮР ДҮН:** зүрхний эмгэг илрүүлэх урьдчилан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэргийлэх үзлэгт 6 настай **6462 хүүхдийг** хамруулж, зүрхний төрөлхийн гажиг илэрсэн 42, судсан дотуурх мэс засал болон нээлттэй мэс засалд орох шаардлагтай 8, хавхлагын хөнгөн зэргийн өөрчлөлттэй 138, хэм алдалттай 11 диспансерын хяналтанд байх шаардлагатай 28 хүүхдийг хяналтандаа аваад байна. | |
| 8 | **БСТ 1.2.2.**<br>Сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн сонсгол бууралт ба чихний төрөлхийн гажгийг эрт илрүүлж, хяналтын тогтолцоог бий болгоно. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | 100 | 150 | Зөвлөх поликлиникийн **Хүүхдийн чих, хамар, хоолойн кабинетаар** 13,486 хүүхдэд үзлэг, багажийн оношилгоо үзүүлснээс чихний эмгэтэй 580 хүүхдийн чихэнд шингэн хурсантай холбоотойгоор сонсгол олдмолоор буурсан байв.<br>Амбулаториор эмийн эмчилгээгээр эдгэрсэн 317 хүүхэд байна. Амбулаторийн хяналтанд одоо байгаа хүүхдийн тоо 32 байна.<br><br>**ҮР ДҮН:** Хүүхдийн чих, хамар, хоолойн эмчийн үзлэгт 13,486 хүүхэд хамрагдаж, өвчний улмаас олдмол сонсгол бууралттай **580 хүүхдийн** 163 хүүхэд хэвтэн эмчлүүлж эмийн эмчилгээгээр 54, мэс ажилбар, мэс заслын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээгээр 129 хүүхэд эдгэрч, одоо **хяналтад 32** хүүхэд байна. | |
| Зорилт 1.3: Эх барихын лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлнэ. | | | | | | | |
| 9 | **БСТ 1.1. 7** Сэргийлж болох эхийн эндэгдлийн түвшинг бууруулах ажлыг зохион байгуулна. | 10.0 (ЭМД-ын сангийн санхүүжилт) | 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцаа | 0 | 0 | ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас зохион байгуулсан сэргийлж болох эхийн эндэгдлийг бууруулах цахим сургалтанд 2025 онд 8 удаа нийт давхардсан тоогоор 210 эмч хамрагдсан байна.<br>Эмнэлгийн хэмжээнд бүх эх барих эмэгтэйчүүдийн эмч, нярайн эмч нар болон мэс засал мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгаас жирэмсэн, төрөх, төрсний дараах эхчүүдэд өгөх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ бүрт “Эмнэлзүйн оношилгоо, эмчилгээний удирдамж” гарган батлуулан, 63 эмнэлзүйн удирдамж, Ерөнхий захирлын А/30, А/31 тоот тушаалаар баг томилуулан Эх барихын тусламж үйлчилгээ үзүүлж байна.<br>**ҮР ДҮН:** Эхийн эндэгдэлгүй ажилласан. | 100% |
| 10 | **БСТ 1.1. 7** Сэргийлж болох нярайн эндэгдлийг | | 1000 амьд төрөлтөд нярайн | 0.8 | 0.6 | Нярайн тусламж үйлчилгээнд дараах эмнэлзүйн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | түвшинг бууруулах ажлыг зохион байгуулна. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | эндэгдлийн түвшин | | | заавруудыг батлуулан ажиллаж байна.<br>Эхийн болон перинатал эндэгдлийг бууруулах эмнэл зүйн аудитын хороо байгуулан, удирдамжыг Ерөнхий захирлын А/31 тоот тушаалаар батлуулсан. Цаашид тус удидамжийн дагуу аудитын баг ажиллана.<br>• Нярайн амьсгалын дистресс хам шинжийн үеийн оношилгоо, эмчилгээний заавар<br>• Нярайн гэдэсний үхжилт үрэвслийн оношилгоо эмчилгээ<br>• Нярайн үжлийн оношилгоо, эмчилгээний удирдамж<br>• Нярайн пневмони үеийн оношилгоо, эмчилгээний заавар<br>• Нярайн гипокси-ишемийн шалтгаант энцефалопатийн үеийн оношилгоо, эмчилгээний удирдамж<br><br>**ҮР ДҮН:** 2025 оны байдлаар 1000 амьд төрөлтөд нярайн эндэгдлийн түвшин 2.4 байгаа нь дэлхийн дундаж (17)-аас 14.6-аар бага, номхон далайн баруун | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эргийн бүсийн дундаж (6)-аас 3.6-аар бага, Монгол улсын дундаж (7.5)-аас 5.1-ээр бага байна. | |
| 11 | **БСТ 1.1.7**<br>Эхийн болон нярайн эндэгдлийн конференцийг тогтмол зохион байгуулж, чанаржуулна. | 5.0 (ЭМД-ын сангийн санхүүжилт) | - Конференцийн тоо<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Эмнэлзүй-эмгэг судлалын хамтарсан хурлыг цаг хугацаанд нь хийж, төлөвлөгөөг 100% хэрэгжүүлсэн. | Үндсэн оношийн зөрүү болон ЭҮД гаргалтыг өмнөх оноос бууруулсан байна. | Нярайн эндэгдэл 6 тохиолдол бүртгэгдсэн байв. 3 тохиолдолд ЭМС-ын А/447 тоот тушаалын дагуу мөн ар гэрийн хүсэлтээр шинжилгээнд ороогүй байна. 2 тохиолдолд эмнэлзүй болон эмгэг судлалын онош үндсэн өвчний нэршил, түүний хүндрэлээр тохирсон. 1 тохиолдол эмнэлзүй болон эмгэг судлалын онош үндсэн өвчний нэршил, түүний хүндрэлээр онош зөрсөн бөгөөд маш ховор тохиолдох 2 талын уушгины гажиг байв. Эмгэг судлалын эмч нартай хамтарсан эмнэлзүйн хурал хийсэн.<br><br>**ҮР ДҮН:** нярайн эндэгдлийн эмнэлзүй болон эмгэг судлалын хамтарсан конференцийг 3 удаа зохион байгуулсан. | 100% |
| 12 | **БСТ 1.1.7.**<br>Нярайн уушигны артерийн гипертензи бууруулах нитроксид аппаратыг шаардлагатай нярайд | 5.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Эмчилгээнд хамрагдсан нярайн тоо | 0 | 20 тохиолдол | **Гипотерми эмчилгээ:**<br>**1.** 37 долоо хоногтой, 2800 гр жинтэй, Апгар 4 оноотой **1 нярайг** хамруулсан.<br>**Оруулсан цаг:** 72 цаг (амин үзүүлэлтүүдийг тогтмол | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтмол хэрэглэж, гипертензийн шалтгаант өвчлөл, эндэгдэлийг бууруулна. | | | | | хянасан, биеийн хэмийг шулуун гэдсэнд 3 цаг тутамд үзсэн, зүрхний хэм алдагдаагүй, ЭЭГ өөрчлөлтгүй байсан)<br>**Эргэн дулаацуулсан цаг**: 12 цаг (зүрхний хэм алдаагүй, ЭЭГ өөрчлөлтгүй байсан)<br><br>**ҮР ДҮН:** Нярайд зулайн ЭХО, тархины цахилгаан бичлэгт өөрчлөлтгүй, таталт үүсээгүй, ямар нэгэн үрэвслийн шинжгүй НЭЭТ-д 7 хоног эмчлэгдээд НЭСТ-т шилжээд 7 хоног эмчлүүлээд эмнэлгээс гарсан нь ор хоногийг бууруулсан байна.<br>**2.** 40 долоо хоногтой, 2000 гр жинтэй, ургийн өсөлтийн саатaлтай, Апгар 2/4 оноотой 1 нярайг хамруулсан.<br>**Оруулсан цаг:** 72 цаг (амин үзүүлэлтүүдийг тогтмол хянасан, биеийн хэмийг шулуун гэдсэнд 3 цаг тутамд үзсэн, зүрхний хэм алдагдаагүй, ЭЭГ өөрчлөлтгүй байсан)<br>**Эргэн дулаацуулсан цаг**: 24 цаг (зүрхний хэм алдаагүй, ЭЭГ өөрчлөлтгүй байсан)<br><br>**ҮР ДҮН:** Нярайд зулайн ЭХО, тархины цахилгаан бичлэгт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрчлөлтгүй, таталт үүсээгүй, ямар нэгэн үрэвслийн шинжгүй НЭЭТ-д 9 хоног эмчлэгдээд НЭСТ-т шилжээд 14 хоног эмчлүүлээд эмнэлгээс гарсан нь ор хоногийг бууруулсан байна.<br>**Тархины цахилгаан бичлэг:** Нярайн гипокси-ишемийн шалтгаант энцефалопати хүнд, хүндэвтэр хэлбэр, нярайн таталт **21 нярайд** Тархины цахилгаан бичлэг хийсэн. Илт таталтын шинжгүй **5 нярайд** тархины цахилгаан бичлэг хийж, таталтыг эрт үед оношилж, эмчилсэн.<br>**ҮР ДҮН:** Гипокси-ишемийн шалтгаант энцефалопатитай **16 нярайд** тархины цахилгаан бичлэг хийж, таталтын голомтыг үгүйсгэсэн нь эмчилгээг цаг алдалгүй эхлүүлэх нөхцлийг бүрдүүлж чадаж байна.<br>**Нярайн уушигны артерийн гипертензи бууруулах эмчилгээ**г зунгагт хахах хамшинжтэй **1 нярай**, уушигны үрэвсэлтэй **6 нярай**, артерийн битүүрээгүй цорго, зууван цонх **нээлттэй 6 нярай**, амьсгал гачаалын хам | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжтэй **8 нярайд** төрснөөс хойш 7 хоногийн дотор iNO 20 ppm-ээр 3 хоног эмчилгээ хийсэн.<br><br>**ҮР ДҮН:** Нярайн уушигны артерийн гипертензи бууруулах эмчилгээг **21 нярайд** хийж, нитроксид эмчилгээ хийлгэсэн нярайн хүчилтөрөгчийн ханамж сайжирч, уушигны артерийн даралт богино хугацаанд 48-72 цагийн дотор буусан. | |
| 13 | **БСТ 1.1.7.** Эмнэлэг хооронд шилжиж буй жирэмсэн эхэд тавих хяналтыг сайжруулан өрх, дүүргийн эмнэлгүүдтэй хамтран ажиллана. | 20.0 (ЭМДСангийн санхүүжилт) | - Хамтран ажилласан эмнэлгийн тоо<br>Эмнэлэг хооронд шилжүүлсэн хүний тоо | Арга хэмжээг төлөвлөн 100% хэрэгжүүлсэн. | Эмнэлэг хооронд шилжүүлэхтэй холбоотой зөрчил гомдол гараагүй байна. | СХД, ХУД-ийн Нэгдсэн эмнэлэг, ЭМТ-тэй 2023 оноос хойш хамтран ажиллаж, мэдээлэл солилцох 163 гишүүн бүхий телеграмм грүпп ажиллуулан ЭНЭҮТ-д төрсөн эх, нярайг өдөр бүр мэдээлдэг. Мөн жирэмсэн, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг харьяаллын дагуу эмчид нь хүлээлгэн өгч мэдээлэл солилцдог. Google форм дээр он тус бүрээр эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байгаа бүх иргэдийн мэдээлэл цаг хугацаа, гэрийн хаяг, холбоо барих 2-с дээш утасны дугаар анхаарал татах зовуурь, онош зэргийг багтаасан мэдээллийн сантай. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **ҮР ДҮН:** Эмнэлэг хооронд шилжүүлэхтэй холбоотой зөрчил гомдол гараагүй. ЭХЭМҮТ-1 нярай, ХӨСҮТ-1 жирэмсэн, 1 төрсний дараах, 9 улаан бурхны халдвартай нийт 12 үйлчлүүлэгч шилжүүлсэн. | |
| 14 | **БСТ 8.3.2.** Хөгжлийн бэрхшээлтэй буюу хэлгүй дүлий, иргэдтэй дохионы хэлээр ойлголцох чадвар бүхий Эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэн сургах, тэдгээртэй харилцах харилцааны хэрэгслүүдийг нэмэгдүүлнэ. | 20.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 45 | 70 | Хэлгүй дүлий, иргэдтэй дохионы хэлээр ойлголцох “Дохионы хэлний самбар” тасаг бүрт байршуулсан. Харааны бэрхшээлтэй иргэдэд “Бариал үсгийн самбар” байршуулсан, мөн ойрын харааны шил болон бичгийн самбар байршуулан ажиллаж байна. Нийт эмнэлгийн 120 ажилтанд самбар, гар утасны ухаалаг апликейшин хэрхэн хэрэглэх талаар сургалт орсон байна. Зөвлөх поликлиникийн тасгийн туслах сувилагчийг “Дохионы хэл”-ний сургалтанд хамруулан гэрчилгээ авсан байна.<br><br>**ҮР ДҮН:** Дохионы хэлийг ашиглах сургалтад эмнэлгийн 120 ажилтныг хамруулан цаашид ашиглах самбар, гар утасны ухаалаг апликейшин суулгасан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | **БСТ 1.1.7.** Жирэмсний хяналт, төрсний дараах үеийн амбулаторийн тусламж үйлчилгээг мөрдөгдөж байгаа удирдамж, журам, зааврын дагуу чанартай, хүртээмжтэй хүргэнэ. | 20.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95% | Төлөвлөсөн арга хэмжээ 95-с дээш хувь хэрэгжсэн байна. | ЭМС-ын 2024 оны 06 сарын 24-ны өдрийн А/292 тоот тушаал "Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам"<br>Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн<br>1. Жирэмсний хяналтын үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам<br>2. Жирэмсний бүлгийн хяналтын журам<br>3. Пренаталь үеийн илрүүлэг, оношилгооны удирдамжуудыг баримтлан ажиллаж байна.<br><br>**ҮР ДҮН:** Дутуу төрөлт, эх, нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор жирэмсний бүлгийн хяналтыг шинээр зохион байгуулж, Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээнд шинээр боловсруулсан 3 эмнэлзүйн удирдамжийг ашиглаж байна. | 100% |
| 16 | **БСТ 1.1.7.** Жирэмсний II 3 сарын ургийн гажиг илрүүлэх ургийн анатомын хэт авиан шинжилгээний үзлэгийн чанар | 30.0 (ЭМДСангийн санхүүжилт) | үзлэгийн тоо | 10 тохиолдол | 20 тохиолдол | Ерөнхий захирлын 2025 оны 07 сарын 09 сарын А/36 дугаар тоот тушаалаар "Эх ургийн анагаах ухааны багийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжийг сайжруулна. | | | | | **Жирэмсний эрт үеийн хромосомын эмгэг** илрүүлэх, албан ёсны гэрчилгээтэй хэт авиан шинжилгээг хийх эрхтэй 2024 онд 2 эмч, 2025 онд 3 эмчийг ЭХЭМҮТ-д хэт авиан мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулснаар одоо 5 эмч ажиллаж, 2025 оны 3 сараас эхлэн жирэмсний эрт үеийн хромосомын эмгэг илрүүлэх нийлмэл илрүүлгийг цогцоор хийж эхэлсэн.<br>**Лабораторийн тасаг** нь эхийн цусанд жирэмсний эрт үед хоёрол тест (PAPP-A, чөлөөт β-hCG) үзэх шинжилгээг хийж, жирэмсний эрт үеийн хромосомын эмгэг илрүүлэх нийлмэл илрүүлгийг цогцоор хийж, эрсдэлийг үнэлж, ЭМС-ын 2024 оны 06 сарын 24-ний өдрийн А/292 тоот тушаалын дагуу ЭХЭМҮТ-ийн Перинатологийн клиникт илгээсэн бөгөөд хромосомын эмгэг батлагдсан тохиолдол байхгүй байна.<br><br>**ҮР ДҮН:** Ургийн оношилгоо 2023 оноос 2-3 дахин нэмэгдсэн. Жирэмсний эрт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үеийн нийлмэл илрүүлэгт 2025 онд **215 эмэгтэй** хамрагдаж, эрсдэлтэй 5 эмэгтэйг илрүүлсэн.<br>Ургийн төрөлхийн хөгжлийн гажигийн илрүүлгээр 2025 онд зүрх судасны эмгэгтэй 3, уруул тагнайн сэтэрхий 3, мэдрэлийн хөгжлийн гажиг 5, Хоол боловсруулах эрхтний гажиг 3, Бөөр шээс дамжуулах эмгэгийн гажиг онд 6, нэг ихэс, нэг амниотой ихэр жирэмсэнгийн ургаас урагт цус юүлэгдэх хам шинж /TTTS/ 3 **нийт 23 эмгэгтэй** нярайг оношилсон. | |
| 17 | **БСТ 1.1.5, 1.1.7.**<br>Умайн хүзүүний хорт хавдрын оношилгоо, эмчилгээ, мэс заслыг үе шаттайгаар эхлүүлнэ | 30.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна. | Зөвлөх поликлиникт нийт 3587 эмэгтэйгээс шинжилгээ авахад 66 хүн өөрчлөлттэй байсан.<br>Шинээр хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний дурангийн кабинетыг нээн ажилуулж, 810 хүнд тусламж үзүүлсэн.<br><br>**ҮР ДҮН:** умайн хүзүүний хавдрын урьдал эмгэгийг илрүүлэн хорт хавдраар өвчилөхөөс өмнө 75 хүнд мэс засал эмчилгээ хийсэн. | 100% |
| 18 | **БСТ 1.1.5, 1.1.7.**<br>Хөхний хоргүй хавдрын мэс засал | 40.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний | - | Төлөвлөсөн арга хэмжээ | Хортой болон хоргүй хавдрын мэс заслын тусламж үйлчилгээг эхлүүлж, | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эмчилгээг үе шаттайгаар эхлүүлнэ | | хэрэгжилтийн хувь | | хэрэгжсэн байна. | төрөлжсөн мэргэшлийн 5 эмч, сувилагч, мэргэжилтэнг сургалтанд хамруулан бэлдэж, ЭМДЕГ-тай тухайн ОХБ-ээр гэрээ байгуулан ажиллаж байна.<br><br>**ҮР ДҮН:** Зөвлөх поликлиникт 2026 эмэгтэйд хөхний үзлэг хийгдэж, маммаграфи болон хөхний хэт авиан тусламж үзүүлсэн. | |
| 19 | **БСТ 1.1.5, 1.1.7.**<br>Хими туяа эмчилгээ болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үе шаттайгаар эхлүүлнэ | 50.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна. | Хими туяа эмчилгээ болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үе шаттайгаар эхлүүлж хүний нөөцийг бэлдэн ЭМДЕГ-тай тухайн ОХБ-ээр гэрээ байгуулан ажиллаж байна.<br><br>**ҮР ДҮН:** Хүний нөөцийг бэлтгэсэн. | 80% |
| 20 | **БСТ 1.1.2, 1.1.7**<br>Ахимаг насны жирэмсний хяналтыг онцгой анхаарч, эрсдэлийг тооцоолох, төрөлтийн төлөвлөгөөг боловсруулж,хэрэгжүүлнэ. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Хяналтын тоо Төрөлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хяналтын тоо 49 | Ахимаг насны жирэмсний болон төрөлтийн явцад үүсэх хүндрэл буурна. | Жирэмсний хяналтанд байгаа 35 наснаас дээш насны жирэмсэн 148 эх байгаа бөгөөд эрсдэлтэй жирэмсний хяналтын эмч дээр хянагдаж, нийт жирэмсний хяналтын 21.1%-г эзэлж байна.<br>2025 онд 36-аас дээш насны 738 эх амаржсанаас 350 эх буюу 47.4% нь кесар мэс заслаар 388 эх буюу 42.6% нь төрөх замаар төрсөн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ахимаг насны жирэмсний 35 эх буюу 4.7% нь анхны төрөлт байсан.<br><br>**ҮР ДҮН:** Жирэмсний хяналтад ахимаг насны жирэмсэн 148 буюу нийт хяналтын 21.1%, 2025 онд 350 эх амаржсан. | |
| 21 | **БСТ 1.1.7.**<br>“Хөхний сүүний донор банк”-ыг үе шаттайгаар байгуулж ажиллана. | 100.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Донор банканд цугларсан сүүний хэмжээ, литрээр | Бэлтгэл ажил 100% хэрэгжсэн | 48 литр сүү | Хөхний сүүг 2025 оны байдлаар 49 литр сүүг цаг тухайд нь зохих журмаар нөөцлөн, нярайн эрчимт эмчилгээний нярай, дутуу бага жинтэй 421 нярайг шаардлагатай үед хооллосон байна.<br><br>**ҮР ДҮН:** 49 литр хөхний сүүг нөөцлөн ашигласан. | 100% |
| 22 | **БСТ 1.1.7.**<br>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/290 дүгээр тушаалаар батлагдсан Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “10 алхам”-ыг хэрэгжүүлнэ. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээ төлөвлөн 100% хэрэгжүүлсэн. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Төрсний дараах ээжүүдийг 100% хөхөөр хооллолтыг дэмжих сургалтанд хамруулсан, нийт сургалтын цаг 140 цаг байна.<br>Зайлшгүй эзэмшвэл зохих онол болон дадлын хангалттай мэдлэг, ур чадварыг байгууллагын ажилтнууудад олгож сургах ажлын хүрээнд 2025 оны 03 сарын 24, 2025 оны 05 сарын 05, 08 сарын 20-нд 3 удаагийн давтамжтай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. Ангир уургаар хооллох, хөхний сүүний ач холбогдол<br>2. Эхийн сүүгээр хооллолтыг талаарх бодлого, хуул эрх зүйн актууд.<br>3. Эхийн сүүгээр хэрхэн хооллох.<br>4. Эхийн сүүгээр хооллолтыг түгээмэл бэрхшээлүүд<br>5. Эхийн сүүгээр хооллолтын дадлууд<br>6. Хүүхдээ эхийн сүүгээр хооллоход эхэд дэмжлэг тусламж үзүүлэх ур чадвар<br>7. Хүүхдийн хооллолтын талаар мэдээлэл цуглуулах, үнэлэх ур чадвар эдгээр сэдвүүдийн хүрээнд нийт 75 эмч, эх баригч, сувилагч нарт сургалт хийв.<br>- ЖЭЭТасагт хөхний сүүний ач холбогдол, ангир уураг, хөхөөр хооллолтын талаар видео хичээл бэлтгэж, тасагт хэвтэн эмчлүүлж байгаа эхчүүдэд сургалтанд өдөр тутам ашиглаж байна.<br>- Төрсний дараа нярайг нэн даруй эхийн энгэрт тэврүүлж, арьс арьсаар шүргэлцүүлж, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхэд хэвийн амьсгалж байвал жинлэх, хэмжих зэрэг тогтсон ажилбаруудыг хойшлуулж төрсний НЭҮНШТ-ийн дагуу 2 цагийн дараа буухад нь тогтмол жин үзэж, амлуулсаны дараа витамин к булчинд тарих, нүдний халдвараас сэргийлэх ажилбаруудыг тогтмол хийж байна. Дээрх үйлдлүүдийг кесар хагалгаагаар төрсөн үед ч эхийн энгэрт тэврүүлж, арьс арьсаар шүргэлцүүлж байна.<br>- Эхийн сүүгээр хооллоход тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор<br>○ Эхчүүдэд хүүхдээ хэрхэн зөв байрлуулах, амлуулах талаар<br>○ Хөхөө саах аргыг<br>○ Эхэд саасан сүүгээ аюулгүй хадгалах талаар тайлбарлаж өгөх<br>Эхэд хүүхдийг эхийн сүүгээр хооллохын ач холбогдлын талаар сургалтыг сардаа 4 удаа улиралдаа 12 удаа хийсэн.<br>- Хүүхдийг зориулалтын бүтээгдэхүүнээр хооллодог нярайн талаарх мэдээлллийг “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэдэглэж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Төрсний дараа эх, хүүхдийг 24 цагийн турш нэг өрөөнд хамт байлгаж байгаа.<br>- Кесар хагалгаагаар төрсөн эхчүүдийг төрсөн цагаас хойш хамт байлгаж, нярай эрүүл бол эх нярайг салгахгүй байлгана.<br>- Угж болон саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаврын талаар зөвлөгөө өгөх.<br>1. “Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай” хуулийг таниулах<br>2. Угж болон саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаварын талаар эхчүүдтэй ярилцаж зөвлөгөө өгч ажиллаж байна.<br><br>**ҮР ДҮН:** Нийт төрсөн нярайг эхний 1 цагт амлуулах ажил 98%, хөхний сүүний 10 алхам хэрэгжүүлэх удирдамж зааврыг боловсруулан батлуулсан. Эмнэлзүйд ашиглаж, нийт 102 эхийн хөхөнд “Хөхний асаргаа” хийсэн байна. Жирэмсэн эмэгтэйг хүүхдээ эхийн сүүгээр хооллоход бэлтгэх, тэдэнд болон гэр бүлд нь эхийн сүү болон хүүхдээ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөхүүлэхийн ач тус сургалтыг жирэмсний хяналтын 198 эхэд, Жирэмсний эмгэгийг эмчлэх тасгийн давхардсан тоогоор 450 эхэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийсэн. | |
| 23 | **БСТ 1.1.7.** Төрөлтийн үеийн туслах “Доала” буюу туслах үйлчилгээг тогтмол ажиллуулна. | 20.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо | Арга хэмжээ төлөвлөн 100% хэрэгжүүлсэн. | Төрөлтийн үеийн Доала үйлчилгээ тогтмолжсон байна. | 1. Төрөлтийн үеийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор төрөх тасагт гэр бүлээрээ амаржих өрөөг шинээр тохижуулан үйл ажиллагаанд оруулан ажиллаж байна<br>2. Төрсний дараах гэр бүлээрэй орох өрөөнүүдэд нийт 7 хос ширээ сандал зэргийг байршуулж үйлчлүүлэгчийн тав тух, ээлтэй орчинг бүрдүүлэн ажиллаж байна.<br>3. Төрөх тасгийн коридорт үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлд зориулсан “ Фото Зоне” -г шинээр санаачилж хийсэн.<br><br>**ҮР ДҮН:** Төрөгч эх бүрт ДОАЛА буюу төрөлтийн хамтрагчийг хэрэгжүүлэн төрөх үед болон төрсний дараах үед хамт байлгаж ээлтэй орчинг бүрдүүлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байна. Нийт төрөлтийн 60% буюу 2440 эхэд Доула буюу төрөлтийн хамтрагчтай тусламж үйлчилгээг үзүүлсэн. | |
| 24 | **БСТ 1.1.7, 1.1.8.** Эрүүл мэндийн сайдын 2014 оны 335 дугаар тушаалаар батлагдсан “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлнэ. | 50.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Төлөвлөсөн арга хэмжээ 100% хэрэгжсэн. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Эх Нярай Эмэгтэйчүүдийн Үндэсний Төвийн Төрөх тасаг нь 20 ортойгоор эх барих, нярайн тусламж үйлчилгээг харъяалал харгалзалгүйгээр 24 цагийн турш тусламж үйлчилгээг үзүүлдэг.<br>НЭҮНШТ-ыг үзүүлэхэд хэрэглэгдэх тоног төхөөрөмж болон шаардлагатай зүйлсийн бэлэн байдлыг хангаж ажилладаг.Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг төрөх тасагт төрөх замаар болон кесар мэс заслаар төрж буй эхчүүдэд хэрэгжүүлэн ажилласан.<br>НЭҮНШТ-ыг үзүүлэхэд зайлшгүй хэрэглэгдэх тоног төхөөрөмж болон шаардлагатай зүйлсийн бэлэн байдлыг хангаж ажилладаг.<br>Тоног төхөөрөмжүүд/төрөх тасагт:<br>Төрөх иж бүрэн автомат ор - 24<br>Дуслын шахуурга-10<br>Ургийн монитор -12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хяналтын монитор -3<br>Хүчилтөрөгч өтгөрүүлэгч-5<br>Салиа соруулах аппарат -14<br>Нярайн дулаацуулагч ширээ-9<br>Ларинскопийн иж бүрдэл том хүн-4<br>Амьсгалын аппарат -1<br>Дефибрилятор монитор-1<br>Вакум насос-1<br><br>**ҮР ДҮН:** 2025 оны эхний 11 сарын байдлаар 4035 эхэд эх барих, нярайн тусламж үйлчилгээг үзүүлж, эх нярайг эсэн мэнд амаржуулсан. | |
| 25 | **БСТ 1.1.7.**<br>Охид, өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлнэ. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Төлөвлөсөн арга хэмжээ 90% хэрэгжсэн. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Амбулаторын тусламж үйлчилгээгээр нийт 99 охидын үзлэг хийгдсэн бөгөөд нийт эмэгтэйчүүдийн үзлэгийн 8,2%-ийг эзэлж байна.<br>Дэлхийн эрүүл мэндийн өдөрт зориулсан “Өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд “ сэдэвт өдөрлөгийг 04-р сарын 12-ны өдөр ХУД-ын 163-р сургуулийн 9-11-р ангийн өсвөр насны хүүхдүүдийг хамруулан зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Бэлгийн замаар дамжих халдвар, Үе тэнгийнхний | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дарамт, дээрэлхэлт” сэдэвт сургалтыг 71 өсвөр насны хүүхдүүдэд хийсэн. ХУД-ын 163-р сургуулийн 9-11-р ангийн өсвөр насны хүүхдүүдийн дунд “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” сэдэвт reel хийж цахим хуудсанд байршуулж олон дагагчтай пэйж хуудас болон өөрийн цахим хаягуудад байршуулж нийт **2300** гаруй хүний хандалт авсан байна.<br>Төвийн бүх хэвтэн эмчлүүлэх тасгуудад ЭМБОС-ын гарын авлага бэлтгэн байршуулан мэдээлэл хүргэж байна.<br>Амбулатороор үйлчлүүлж буй иргэдэд, “Хүүхдийн эсрэг үйлдэгдэх хүчирхийллийг зогсооё”, “Бэлгийн замаар дамжих халдвар”, “Ангир уураг ба түүний ач тус”, “Төрсний дараах үеийн сэтгэл зүй”, “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж”, “Хөх, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх нь” сэдвүүдээр 8 төрлийн зөвлөмж гарын авлага бэлтгэн давхардсан тоогоор **291** иргэдэд тараасан байна.<br>Амбулаторид байрлах 2 зурагтаар 6 төрлийн видео | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | контент бэлтгэн 210 удаа хүргэлээ. Төвийн фэйж хуудас болон бусад дүүргийн олон дагагчтай групп хуудсууд дээр нийт 15 удаа мэдээлэл байршуулж **13800** хүн мөн үетэй харьцуулахад олон нийтийн цахим сүлжээгээр мэдээлэл байршуулах тоо цахим сүлжээний тоо 3-аар нэмэгдэж баршуулах мэдээллийн тоо 25 хувиар нэмэгдсэн байна.<br><br>**ҮР ДҮН:** Охид, өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Охид, өсвөр үеийн нөхөн үржихүйн чиглэлээр Дутуу тээлт судлалын тасгийн Б.Халиун эмч суралцаж, хүүхдийн эмч Б.Нямсүрэн өсвөр үеийн эмчээр төгссөн. | |
| 26 | **БСТ 1.1.7.**<br>Төрөлтийн үеийн ба эх барихын ажилбаруудын өвдөлт намдаах заавар, удирдамж боловсруулж мөрдөн ажиллана. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Төлөвлөсөн арга хэмжээ 90% хэрэгжсэн. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Төрөлтийн үеийн ба эх барихын ажилбаруудын өвдөлт намдаах заавар, удирдамж боловсруулжан эмнэлзүйд хэрэглэн ажиллаж байна.<br>1. Мэс заслын өрөөнөөс бусад нөхцөлд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээгүйжүүлэг тайвшруулалт хийх тухай<br>2. Төрөлтийн үеийн ба эх барихын ажилбаруудын өвдөлт намдаах заавар удирдамж<br><br>**ҮР ДҮН:** Төрөлтийн үеийн ба эх барихын ажилбаруудын өвдөлт намдаах заавар, удирдамж боловсруулж мөрдөн ажиллаж байна. | |
| 27 | **БСТ 1.1.7**<br>Тэмбүү, ХДХВ, гепатит В, С вирусийн халдвар эхээс хүүхдэд дамжихыг таслан зогсоосон ДЭМБ-ын үнэлгээнд хамрагдана. | 20.0 (ЭМДСангийн санхүүжилт) | - Тайлан Үнэлгээний хувь | Арга хэмжээ төлөвлөн 100% хэрэгжүүлсэн. | Эхээс урагт тэмбүү, ХДХВ, гепатит В, С вирусийн халдвар дамжихыг бууруулна. | Эрсдэлтэй жирэмсний хяналтанд Элэгний В вирустай жирэмсэн 22 жирэмсэн, Элэгний В, Д вирустай жирэмсэн 16 жирэмсэн, Тэмбүүгийн халдвартай 6 эх хянагдаж байна.<br>- В гепатитын эсрэг дархлаажуулатыг нийт 3956 нярайд хийсэн байна.<br>- Иммуноглобулин /Hepabig/ элэгний вирустэй эхээс төрсөн 49 нярайд хийсэн байна<br><br>**ҮР ДҮН:** Тэмбүү, ХДХВ, гепатит В, С вирусийн халдвар эхээс хүүхдэд дамжихыг таслан зогсоосон ДЭМБ-ын үнэлгээнд хамрагдах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | **БСТ 1.1.7** Жирэмсний хяналт болон төрсний дараах гепатит B, C вирусийн халдварын эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 40.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Хамрагдалтын тоо | Жирэмсний хяналтанд элэгний B болон C вирусын халдвартай эх нийт 34 хамрагдсан байна. | Жирэмсний хяналт болон төрсний дараах гепатит B, C вирусийн халдварын эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Жирэмсний хяналт болон төрсний дараах гепатит B, C вирусийн халдварын эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэхээр харьяа дүүрэг, ХӨСҮТ-тэй хамтран эхийг хяналтанд нь илгээж байна.<br><br>**ҮР ДҮН:** Иммуноглобулин /Hepabig/ элэгний вирустэй эхээс төрсөн **49 нярайд** хийсэн байна. | 100% |
| 29 | **БСТ 1.1.7** "Умай судасгүйжүүлэх" мэс заслыг нутагшуулан эмнэл зүйд үе шаттайгаар нэвтрүүлнэ. | 50.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Эхийн ноцтой хүндрэлээс сэргийлсэн 4 тохиолдол байна | Тусламж үйлчилгээний чанар, үр дүн сайжирсан байна | Эмнэлзүйн удирдамж боловсруулан батлуулсан. Дотоодын болон гадаадын эрдэм шинжилгээний хуралд үр дүнгээ танилцуулан 3 удаа илтгэл хэлэлцүүлсэн.<br>□ "Эх хүүхдийн эрүүл мэнд-эрдэм судлал" олон улсын хуралд "Төрсөний дараах цус алдалтын үед ташааны дотор артерийн судсыг боох мэс засал эмчилгээ" сэдвээр аман илтгэл<br>□ "FIGO 2025"-эх барих эмэгтэйчүүдийн олон улсын холбооны 25-р олон улсын хуралд "Төрсний дараах цус алдалтын үед ташааны дотор артерийн судсыг боох мэс засал эмчилгээний үр дүн" сэдвээр Монгол улсаа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлж ханын илтгэл хэлэлцүүлсэн.<br><br>**ҮР ДҮН:** 2025 оны байдлаар “Умай судасгүйжүүлэх” мэс заслыг Эхийн ноцтой хүндрэлээс сэргийлэн **12 тохиолдлыг** амжилттай хийсэн. | |
| 30 | **БСТ 1.1.7**<br>Эмэгтэй нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс заслыг эмнэл зүйд нэвтрүүлэн, нутагшуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 30.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Эмэгтэйн нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс заслыг 2 тохиолдолд хийсэн байна | Тусламж үйлчилгээний чанар, үр дүн сайжирсан байна | Умай авсан тохиолдлууд цус алдалттай хүндэрсэн тохиолдол дээр амь насны заалтаар хийгдсэн. “Төрсний дараах их хэмжээний цус алдалтын үед ташааны дотор артерийн судас боох журам” батлуулан мөрдөж ажиллаж байна.<br><br>**ҮР ДҮН:** “Ташааны дотор артерийн судсыг боох мэс заслын арга” нэвтрүүлэн 15 хүнд их хэмжээний цус алдалтын үед цус тогтоон амь нас аварч, 6 хүнд умай хадгалж үлдсэн. | 100% |
| 31 | **БСТ 1.1.7**<br>Төрөлт сэдээлтийн орчин үеийн шинэ дэвшилтэд аргыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлж, хярзангийн урагдлыг оёх зангилаагүй шинэ арга техник нэвтрүүлнэ. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Гардан үйлдлийн стандарт, техник боловсруулсан үр дүн | Эмч нарын практикт суурилсан сургалт хийгдсэн. | Хярзангийн урагдлыг оёх шинэ арга техник нэвтрүүлэн хярзангийн шархны хоёрдогч | 2025 онд Олон улсын удирдамж, зөвлөмжөөс шинэчлэлт хийж:<br>• Төрөлтийн сэдээх болон эрчимжүүлэх эмнэл зүйн удирдамж<br>• Төрөлтийн сэдээх болон эрчимжүүлэх үеийн зөвшөөрлийн хуудсыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | халдварыг бууруулна. | шинэчлэн, мөрдөж ажиллаж байна.<br><br>**ҮР ДҮН:** Хярзангийн урагдалтай төрсөн 54 эхэд зангилаагүй шинэ арга техникээр тусламж, үйлчилгээ үзүүлсэн. | |
| Зорилт 1.4: Хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлнэ. | | | | | | | |
| 32 | **БСТ 1.2.2.**<br>Хүүхдийн ерөнхий мэс заслын тусламж, үйлчилгээг үе шаттайгаар хөгжүүлнэ. | 50.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Үйлчлүүлэгчийн тоо | Хэвлийн хөндийн нээлттэй мэс заслын тусламж үйлчилгээг 1769 үзүүлсэн. | Хэвлийн хөндийн дурангийн мэс заслын тусламж үйлчилгээг хөгжүүлж, тусламж үйлчилгээний чанар сайжирна. | Хүүхдийн мэс заслын амбулаторийн тусламж, үйлчилгээг сүүлийн 4 жилд эрс өссөн үзүүлэлттэй байна. 2025 онд 10 сарын байдлаар нийт 17,104 хүүхдэд амбулаторийн тусламж, үйлчилгээг үзүүлснээс:<br>• Хүүхдийн ерөнхий мэс заслын эмчийн үзлэгт 18% (3097)<br>• Чих хамар хоолойн мэс заслын эмчийн үзлэгт 79% (13486)<br>• Эрүү нүүрний мэс заслын эмчийн үзлэгт 3% (521) нь хамрагдсан.<br>Хүүхдийн мэс заслын тасаг нь 2022 оны 10 дугаар сараас эхлэн нийт 8,571 хүүхдэд хэвтүүлэн эмчилгээ, үйлчилгээг үзүүлсэн. 2025 оны 10 дугаар сарын сүүлийн долоо хоногийн байдлаар нийт 3,361 хүүхэд хэвтэн эмчлүүлж байгаа нь тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тасгийн үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй явагдаж байна.<br>Хэвлийн хөндийн дурангийн мэс заслын тусламж, үйлчилгээг хөгжлүүлэх ажлын хүрээнд цөсний хүүдийн чулуу 2, мухар олгойн үрэвсэл 2, төмсөгний 1 талын судасны бүдүүрэл варикоцель 1, оношилгооны журмаар хэвлий дурандаж биопси шинжилгээг 1 удаа дурангаар хийсэн.<br>Хүүхдийн ерөнхий мэс засалын тасагт 2025 онд 2936 хүүхэд хэвтэн эмчлүүлсэнээс ерөнхий мэс засал, мэс ажилбарын тоо – 1480, эмийн эмчилгээнд – 461 хамрагдсан.<br>Хүүхдийн зөвлөх поликлиникийн ерөнхий мэс заслын эмчийн үзлэгт 3,180 хүүхэд хамрагдсан. Боолт 3,505 хүүхдэд цэвэр боолт 159, бохир боолт 2352, амбулаторын боолт 816 тусламж үзүүлсэн байна.<br>Хүүхдийн мэс заслын эмч нар Төрсний дараах нярайд мэс заслын үзлэг хийж, пневмоторакс оноштой 5 хүүхдэд амь насны заалтаар цээжний хөндийн хатгалт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гуурс байрлуулах мэс ажилбар хийсэн.<br><br>**ҮР ДҮН:** Хүүхдийн мэс заслын тасаг нь 2022 оны 10 сараас үйл ажиллагааг эхлүүлэн нийт **8,571 хүүхдэд** мэс заслын тусламж, эмчилгээг үзүүлж, **2025 онд 2,936 хүүхдэд** хүүхдийн мэс заслын төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг **5 чиглэлээр** үзүүлж, хүүхдийн ерөнхий мэс засал 50.4% (1,480), хүүхдийн чих хамар хоолойн мэс засал 41% (1,203), хүүхдийн эрүү нүүрний мэс засал 8,6% (253) хүүхдэд нийт 2,936, хүүхдийн нүдний мэс заслын эмч 2025 оны 11 сараас ажиллаж, 12 хүүхдэд мэс засал эмчилгээ хийсэн. Хүүхдийн бөөрний мэс заслын чиглэлээр Э.Болдхуяг эмч суралцаж байна. | |
| 33 | **БСТ 1.2.2.**<br>Хүүхдийн чих хамар хоолойн мэс заслын тусламжийг хөгжүүлнэ. | 30.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Үйлчлүүлэгчийн тоо | АТЕ, тимпанопластикийн тусламж үйлчилгээг 344 хүүхдэд үзүүлсэн. | Хамрын хөндийн дурангийн мэс заслыг нэвтрүүлж, тусламж үйлчилгээний чанар сайжирна. | Хүүхдийн чих хамар хоолой эмгэг судлалын тасагт 2025 онд нийт 1,203 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлснээс 569 хүүхэд мэс засалд орсон бөгөөд үүнээс төлөвлөгөөт мэс засал 375 эмчлүүлсэн ба яаралтай мэс засал 157 эмчлүүлсэн тус тус ээлж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна.үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн. чих хамар хоолой өвчитөн 334 мэс засал орсон бөгөөд үнээс төлөвлөгөөт мэс засал 310 эмчлүүлсэн ба 15,3% /өмнөх оноос 86,5%-иар өссөн/, яаралтай мэс засал 34 эмчлүүлсэн 1,6% /өмнөх оноос 15,6%-иар өссөн/ тус тус эзэлж байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмж 86,5%-иар нэмэгдсэн байна. Хүүхдийн чих хамар хоолой эмгэг судлалын тасаг нь хэвтэн эмчлүүлэх хэсэгт хүүхдийн чих хамар хоолойн мэс заслын 3 эмч, хүүхдийн ерөнхий мэргэжлийн эмч 1 тус тус ажиллаж байна. Хүүхдийн зөвлөх поликлиникт хүүхдийн чих хамар хоолойн мэс заслын 1 эмч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.2025.01.01-2025.12.02 хооронд нийт 1203 хүүхэд хэвтэн эмчлүүлэв. Үүнээс нийт мэс засал, мэс ажилбарын тоо – 642 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **ҮР ДҮН:** Хүүхдийн чих хамар хоолойн мэс заслын амбулаторийн тусламж үйлчилгээг 13,486 хүүхдэд үзүүлсэн нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад **86%-иар нэмэгдсэн.** Хүүхдийн чих хамар хоолойн эмгэг судлалын тасагт 1,203 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлснээс 569 хүүхэд мэс засалд орсон бөгөөд үүнээс төлөвлөгөөт мэс засал 375 эмчлүүлсэн ба яаралтай мэс засал 157 хүүхдэд хийсэн нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад **64%-иар нэмэгдсэн** байна.<br>Хүүхдийн чих хамар хоолойн мэс заслын төрөл 5-аар нэмэгдэж, 15 оношийн хамааралтай бүлэг (ОХБ)-ээр үзүүлж байна | |
| 34 | **БСТ 1.2.2.**<br>Хүүхдийн эрүү нүүрний мэс заслыг өргөжүүлнэ. | 20.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Үйлчлүүлэгчийн тоо | Эрүү нүүрний мэс заслыг 236 хүүхдэд үзүүлсэн | 250 хүүхдэд мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлж, тусламж үйлчилгээний чанар сайжирна | Хүүхдийн эрүү нүүрний мэс заслын тусламж, үйлчилгээг 253 хүүхдэд үзүүлж, амбулаториор 267 хүүхдүүд нийт 520 хүүхдэд эрүү, нүүрний мэс заслын тусламж, үйлчилгээг дараах 5 оношийн хамааралтай бүлэг (ОХБ)-ээр үзүүлсэн.<br>Q38.0 Хэл уруулын хөвч уртасгах мэс засал – 47.04% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | L02.0 Нүүрний арьсны буглаа, хатиг ба мундас – 39.53%<br>L04.0 Нүүр, толгой ба хүзүүний цочмог лимфаденит (мэс засал) – 10.28%<br>D21.0 Зөөлөн эдийн хоргүй хавдар – 0.40%<br>L98.9 Арьс ба арьсан доорх эслэгийн эмгэг, тодорхойгүй (мэс засал) – 2.77%<br><br>**ҮР ДҮН:** Хүүхдийн эрүү нүүрний **мэс заслын** тусламж, үйлчилгээг **253 хүүхдэд** үзүүлж, амбулаториор 267 хүүхдүүд **нийт 520 хүүхдэд** эрүү, нүүрний мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлсэн. | |
| 35 | **БСТ 1.2.2.** Хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлнэ. | 30.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Нэмэгдсэн төрөлжсөн тусламж үйлчлгээний төрөл, тоо | Хүүхдийн дотрын 5 чиглэлээр тусламж, үйлчилгээг үзүүлж байна | Төрөлжсөн тусламж үйлчилгээний төрөл, тоо, чиглэлийг нэмэгдүүлсэн байна. | Хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн 9 чиглэл (өсвөр үе, харшил, нярай, зүрх судас, мэдрэл, дотоод шүүрэл, уушги, бөөр, хоол боловсруулах)-ээр амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэх 5 тасатг нийт 16,123 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.<br>Хүүхдийн зөвлөх поликлиник 79,748 хүүхдэд амбулаторийн тусламж, үйлчилгээг үзүүлсэнээс: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • 45% (36,274) нь амьсгалын замын эмгэгтэй,<br>• 16% (13,486) нь чих хамар хоолойн эмгэгтэй,<br>• 12% (9,743) нярайн эмгэгтэй,<br>• 9% (7,273) нь зүрх судасны эмгэгтэй,<br>• 6% (4,829) нь хоол боловсруулахын эмгэгтэй,<br>• 3% (3,097) нь мэс заслын эмгэгтэй,<br>• 1% (521) нь эрүү нүүрний мэс заслын эмгэгтэй,<br>• 3% (3,080) нь бөөрний эмгэгтэй ,<br>• 1% (1,445) нь мэдрэлийн эмгэгтэй байсан. 2025 оны 04 сард дотоод шүүрлийн болон харшлын, өсвөр үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр хүүхдийн эмч Б.Нямсүрэн, Ц.Отгонбаяр, Б.Ганчимэг эмч нарыг төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр сургалтанд хамруулсан ба 10 сараас эхлэн 3 чиглэлээр тусламж, үйлчилгээг нэмэгдүүлсэн.<br><br>**ҮР ДҮН:** Хүүхдийн дотрын төрөлжсөн мэргэжлийн **9 чиглэл** (өсвөр үе, харшил, нярай, зүрх судас, мэдрэл, дотоод шүүрэл, уушги, бөөр, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хоол боловсруулах)-ээр амбулаторийн тусламж, үйлчилгээг **79,748 хүүхдэд**, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг **16,123 хүүхдэд** үзүүлсэн. | |
| 36 | **БСТ 1.2.2.**<br>Дутуу нярайн тусламж, үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлнэ. | 30.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Үйлчлүүлэгчийн тоо | 93 дутуу нярайд тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 100 дутуу нярайд тусламж үйлчилгээ үзүүлж, тусламж, үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлнэ. | Нийт төрөлтийн 11,6% нь буюу 209 нярай хугацаанаас өмнө дутуу төрсөн. Үүнээс 68 нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлсэн бөгөөд биеийн жин<br>• 2500гр –аас дээш 29<br>• 2000-2499гр 60<br>• 1500-1999гр 24<br>• 999гр-аас доош 2 нярай тус тус байсан.<br>Нярайн эмгэг судлалын тасагт тээлтийн нас нь 28-37 долоо хоногтой, 1200-2500 гр жинтэй 90 дутуу нярайд эмийн эмчилгээ, асаргаа, сувилгаа, тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн Төрсний дараах тасгаас нийт 93 нярай, Нярайн эрчимт эмчилгээний тасгаас 19 нярайг шилжүүлэн авч эмчилсэн.<br><br>**ҮР ДҮН:** Нийт төрөлтийн 11,6% нь буюу 209 нярай хугацаанаас өмнө дутуу төрсөн. Үүнээс 68 нярай | 84% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлсэн. | |
| 37 | **БСТ 1.2.8.**<br>Нярайн сонсгол, дутуу нярайн ретинопати, түнхний үений дутуу хөгжлийн оношилгоо, шинжилгээг өргөжүүлж, үр дүнг тооцно. | 35.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Үйлчлүүлэгчийн тоо | | 1984 нярайд сонсголын скрининг, 4236 нярайд хэт авиан оношилогоо, зүрхний скрининг 4238 хийсэн. | Нярайн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Нярайн скринингийг 6 төрлөөр төрсний нийт нярайдаа үзүүлж байна.<br>• Нийт 4060 Түнхний хэт авиан скрининг -Type B-988 нярай<br>• Нийт 4060 Зүрхний скрининг- 125 нярай зүрхний эход харуулахад 16 нярай зүрхний төрөлхийн гажиг оношлогдсон.<br>• Нийт 3020 Сонсголын скрининг-92 нярайг сонсгол давтан шалгуулахаар зөвлөгөө өгч чих хамар хоолойн эмчийн хяналт, үзлэгт явуулсан.<br>• Нийт 4060 Нүдний улаан рефлекс-310 нярай, давтан үзлэг буюу нүдний эмчийн үзлэгт төрөлхийн болрын цайлт-1, торлогийн цус харвалт 1 оношлогдсон.<br>• Нийт 3080 Нярайн зулай хэт авиан скрининг-64 нярай нярайн тархины цус харвалт (дутуу нярай) оношлогдсон.<br>• Бодисын солилцооны илрүүлэг- 2025 оны 9 сараас нийт 214 нярайг хамруулсан | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **ҮР ДҮН:** Нярайн скринингийг 6 чиглэлээр хийж, түнхний ЭХО шинжилгээнд 4060 нярайг хамруулан Type B 988 нярай, хөдөлгөөнт пульсоксиметрээр 4060 нярайг үнэлж, зүрхний төрөлхийн гажигтай 16 нярай, сонсголын бичлэгээр 3020 нярайг үнэлж, давтан шалгах шаардлагатай 92 нярай, нүдний улаан рефлекс шалгах аппаратаар 4060 нярайг үнэлж, төрөлхийн болрын цайлт 1, торлогийн цус харвалт 1 нярай, зулайн ЭХО шинжилгээнд 3080 нярайг хамруулан тархины цус харвалттай 64 нярай, өсгийнөөс дусал цус авч хатаан бодисын солилцооны эмгэг илрүүлэх шинжилгээнд 214 нярайг хамруулсан. | |
| Үйл ажиллагааны зорилт 1.5: Эх, ургийн анагаах ухаан, нярайн эрт оношилгоог бэхжүүлэх, перинатологийн тусламж, үйлчилгээг нэвтрүүлж эхэлнэ. | | | | | | | |
| 38 | **БСТ 1.3.1.** Перинаталогийн эх ургийн анагаах ухааны төвийг үе шаттайгаар байгуулж хөгжүүлнэ. | 150.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээг төлөвлөн 96% хэрэгжүүлсэн. | Перинаталогийн эх ургийн анагаах ухааны төвийг үе шаттайгаар байгуулна. | Ерөнхий захирлын 2025 оны 07 сарын 09 сарын А/36 дугаар тоот тушаалаар “Эх ургийн анагаах ухааны багийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. **Эх ургийн анагаах ухааны нэгжийг** байгуулж, багийн ахлагчаар Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээ эрхэлсэн дэд захирал, зөвлөх эмч Ж.Оюунцэцэг, гишүүдэд Жирэмсний эмгэгийн эмчлэх тасгийн эрхлэгч Л.Цэвэлмаа, Дутуу тээлт судлалын тасгийн эрхлэгч О.Алтанзул, Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч Б.Төмөрбаатар, Нярайн тасгийн эрхлэгч Ч.Батням, Удамзүйн лабораторийн эмнэлзүйн эмч Д.Урангоо, Удамзүйн лабораторийн цитогенетикч эмч Д.Орлом, Перинатологич, эх барих эмэгтэйчүүдийн эмч Ө.Отгонжаргал, Эмгэг судлалын эмч Н.Батдорж нар ажиллаж байна.<br>**Пренатологийн** эмч нарыг үе шаттайгаар сургалтад хамруулан 2024 онд Б.Лхагвасүрэн эмч төгссөн, 2025 онд Эх барих эмэгтэйчүүдийн эмч Ө.Отгонжаргал ЭХЭМҮТ-д Эх ургийн анагаах ухааны чиглэлээр суралцаж, 2026 оны 2 дугаар сард төгсөнө.<br>**Жирэмсний эрт үеийн нийлмэл илрүүлэгт** 2023 онд 82 эмэгтэй хамрагдаж, эрсдэлтэй 1, 2024 онд 156 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмэгтэй хамрагдаж, эрсдэлтэй 3, 2025 онд 215 эмэгтэй хамрагдаж, эрсдэлтэй 5 эмэгтэйг илрүүлсэн.<br>**Ургийн төрөлхийн хөгжлийн гажигийн илрүүлгээр** зүрх судасны эмгэгтэй 2023 онд 1, 2024 онд 3, 2025 онд 3, уруул тагнайн сэтэрхий 2023 онд 2, 2024 онд 2, 2025 онд 3, мэдрэлийн хөгжлийн гажиг 2023 онд 2, 2024 онд 3, 2025 онд 5, Хоол боловсруулах эмгэгийг гажиг 2024 онд 2, 2025 онд 3, Бөөр шээс дамжуулах эмгэгийн гажиг 2023 онд 1, 2024 онд 3, 2025 онд 6, Яс, булчингийн гажиг 2024 онд 1, Амьсгалын тогтолцооны эмгэг 2024 онд 1, нэг ихэс, 1 амнионтой ихэр жирэмсэнгийн ургаас урагт цус юүлэгдэх хам шинж /TTTS/ 2023 онд 2, 2024 онд 2, 2025 онд 3, бусад (лимфангиома) 2024 онд 1 оношлогдсон.<br>**ҮР ДҮН:** Ургийн оношилгоо 2023 оноос 2-3 дахин нэмэгдсэн. | |
| 39 | **БСТ 1.1.4, 1.3.1, 1.3.2, 1.3.3.** | 100.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээг төлөвлөн 92% хэрэгжүүлсэн. | Үргүйдлийн үеийн тусламж үйлчилгээг | Зөвлөх поликлиникээр үргүйдлийн 229 удаагийн үзлэг хийгдсэн дотоод | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Үргүйдлийн үеийн тусламж үйлчилгээг үе шаттайгаар хөгжүүлнэ. | | | | эхлүүлсэн байна. | шүүрлийн 2263 үзлэг хийгдсэн байна.<br><br>**ҮР ДҮН:** Үргүйдлийн оношилгоог эмэгтэйчүүдийн дааврын шинжилгээгээр батлан, эмийн эмчилгээний хяналтанд 32 эмэгтэй хянаж байснаас 9 эмэгтэй жирэмсэн болж жирэмсэн үеийн тусламж үйлчилгээ авсан. | |
| 40 | **БСТ 1.1.4, 1.3.1, 1.3.3, 3.3.4, 3.3.5.** Удамзүйн лабораторийн үйл ажиллагааг үе шаттайгаар хөгжүүлнэ. | 50.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Хийгдсэн шинжилгээний тоо, тайлан | Төлөвлөгөөг 91% хэрэгжүүлсэн. | Удамзүйн лабораторийн үйл ажиллагааг үе шаттайгаар эхлүүлсэн байна. | Удамзүйн лабораторийн багаж тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, хүний нөөцийг бэлтгэсэн.<br><br>**ҮР ДҮН:** снаар хромосомын өвчнийг ураг үед нь эрт илрүүлэх пренатал үеийн илрүүлэг шинжилгээ болох хоёрол тест /PAPP-A, HCG/ шинжилгээг 33 хүнд хийсэн байна. | 100% |
| СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО ХОЁР:<br>Сургалт судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж, гадаад харилцааг хөгжүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 2.1: Сургалт, эрдэм шинжилгээг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 41 | **БСТ 2.2.1, 2.2.2.** Гадаадын улс орнуудын эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээний | 80.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Тайлан | Гадаадын 8 байгууллагатай хамтын ажиллагааг хэрэгжүүлж ажилласан ба төлөвлөгөөг | Гадаадын улс орнуудын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтворжиж, | • БНСУ-ын Хүрээ ротари клубтай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд нярайн тусламж үйлчилгээнд шаардлагатай нярайн биеийг бүхэлд нь 360 градус фото туяагаар шарж, шарлалтыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулна. | | | 100% хэрэгжүүлсэн. | нэмэгдсэн байна. | хурдан хугацаанд бууруулах аппарат 3 ширхэг, суурийн ЭХО аппарат 1, зөөврийн ЭХО аппарат 1 ширхэг, зөөврийн пульсоксиметр 4 ширхэг, билиметр 5 ширхэг, CPAP аппарат 4 ширхэг тоног төхөөрөмж гардуулах, нээлтийн хонх цохих үйл ажиллагаа 2025 оны 05 дугаар сарын 28-ний өдөр зохион байгуулагдсан.<br>• Мөн Хонконгийн Туул ротари клуб, Энэтхэг Монголын эрүүл мэндийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан гадаад, дотоод сургалт, солилцоо хөтөлбөр хэрэгжүүлж байна.<br>• Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээг нутагшуулах төслийн хүрээнд БНЭУ-ын Сарводая эмнэлгийн захирал ноён Амит Кумар Аггарвал, БНЭУ-ын Альянс Эрүүл Мэндийн Солюшнз компанийн захирал Доктор Виреш Махажан нартай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, гэрээний хүрээнд үйл | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаануудыг төлөвлөн ажиллаж байна.<br>• БНСУ-ын Чам Чуван эмнэлэгтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хүүхдийн эмч нарыг богино хугацааны дадлага сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>• ДЭМБ-аас зохион байгуулсан Эх, нярайн эрүүл мэндийн хяналтын платформ судалгаанд Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв, Эх барих эмэгтэйчүүдийн үндэсний төв эмнэлэг 1200 төрөлтийн түүхэнд хяналт хийн дата цуглуулсан амжилттай оролцсон.<br>• ДЭМБ-аас зохион байгуулсан RSV вирусын судалгаанд 1040 хүүхдийг хамруулахаар хүүхдийн эмч нар оролцсон.<br>• Солонгос улсын Sophia Women's Clinic –тэй хамтран ажиллах гэрээ, санамж бичигт 2025 оны 11 сарын 13-ны өдөр Ерөнхий захирал А.Эрдэнэтуяа, Sophia Women's Clinic –н менежер Woo, Heon нар гарын үсэг зурлаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Алслагдсан сум хороодын иргэдэд харааны гажгийн тусламж үйлчилгээг ойртуулах” төслийн хүрээнд ОРБИС ОУБ-тай хамтран нүдний кабинет шинээр нээн ажилуулж эхэлсэн бөгөөд нүдний үзлэг оношилгоо хийх шаардлагатай тоног төхөөрөмжийг ОРБИС ОУБ-аас хангаж өгсөн.<br>• БНСУ улсын “СОФИЯ” эмэгтэйчүүдийн мэс заслын эмнэлэгтэй хамтран ажиллах санаж бичигт гарын үсэг зурсан бөгөөд тус гэрээний хүрээнд Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгээс 30 эмчийг БНСУ дахь “СОФИЯ” эмнэлэгт орчин үеийн нөхөн үржихүйн эрхтний мэс засал, үтрээ чангалах, давсаг сойх мэс заслын дадлага сургалтанд хамруулан ажиллахаар заагдсан бөгөөд 2025 оны 12 сард I ээлжийн эмч нар БНСУ-руу явахаар төлөвлөгдсөн.<br><br>**ҮР ДҮН:** Хамтын ажиллагааны санамж бичгийг БНСУ-ын Хүрээ ротари клуб, Хонконгын Туул ротари клуб, Энэтхэг Монголын эрүүл мэндийн хамтын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааны байгууллага, БНЭУ-ын Сарводая эмнэлгийн захирал ноён Амит Кумар Аггарвал, БНЭУ-ын Альянс Эрүүл Мэндийн Солюшнз компанийн захирал Доктор Виреш Махажан, БНСУ-ын Чам Чуван эмнэлэг, БНСУ улсын “СОФИЯ” эмэгтэйчүүдийн мэс заслын эмнэлэгтэй байгуулсан.<br>ДЭМБ-тай хамтарсан 2 судалгаанд эх барих эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмч нар оролцсон. | |
| 42 | **БСТ 1.1.8, 2.1.3.**<br>Нийт хүн амд хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх асуудлаар мэдээлэл, сурталчилгааны нөлөөллийн цуврал интервенцийг сар бүр мэдээллийн хэрэгслээр тогтмол хийнэ. | 20.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Боловсруулж түгээсэн цуврал мэдээллийн тоо | 12420 гаруй мэдээллийг боловсруулж түгээсэн. | Мэдээлэл, сурталчилгааны цуврал интервенцийг сар бүр мэдээллийн хэрэгслээр тогтмолжуулсан байна. | Хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх асуудлаар мэдээлэл, сурталчилгааны нөлөөллийн цуврал интервенцийг сар бүрийн давтамжтайгаар 19 удаа шинэчлэн байршуулсан.<br>• Төвийн цахим хуудас,<br>• Хан-Уул эрүүл мэндийн төв,<br>• Олон нийтийн цахим сүлжээ болон фейсбүүк Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп,<br>• Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп,<br>• Буянт Ухаа-2 хороолол,<br>• Шүрт хотхоны групп,<br>• Өлзийт хорооллын оршин суугчдын групп<br>• Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 117200 хүн хандалт хийсэн.<br>Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх тухай мэдээллийг контентийг фейсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж 2400 иргэдээс хандалт авсан байна<br> ARSLAN.MN сайтаар “ Эмэгтэйчүүдийн хавдрын талаар мэдээлэл” , “Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчин, үргүйдэл”-н тухай ярилцлага өгсөн. Эдгээр мэдээлэл Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн вейб хуудсаар, фейсбүүк пейж хуудсаар шейрлэгдэн олон мянган хандалт авж байсан.<br> Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн фейсбүүк пейж хуудсаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. "УМАЙН МИОМ БУЮУ УМАЙН ХОРГҮЙ ХАВДРЫН ҮЕД ХИЙГДЭХ УМАЙ СУДАСГҮЙЖҮҮЛЭХ МЭС ЗАСАЛ ГЭЖ ЮУ ВЭ?"<br>2. УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХАВДРААС СЭРГИЙЛЬЕ!!! Видео мэдээлэл байршуулсан 4,9 сая хандалт авсан байна.<br>Төвийн фейсбүүк групп болон веб хуудасны "Эмч зөвлөж байна" буланд хавдраас урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж, мэдээллийг сар бүр тогтмол хүргэн ажиллаж байна. Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн фейсбүүк хаяг нь 3000 гишүүнтэй.<br>Амбулаториор үйлчлүүлж буй иргэдэд "Хүүхдийн хорт хавдарын өвчлөлийн тухай", "Эмэгтэйчүүдийн зонхилон тохиолдох хорт хавдараас урьдчилан сэргийлэх" нь сэдвүүдээр сурталчилгааг нийт 121 удаа явуулж 12 төрлийн гарын авлага бэлтгэн 25750 гаруй иргэдэд мэдээлэл хүргэсэн.<br>Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх тухай мэдээллийг контентийг фейсбүүк хуудсаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дамжуулан иргэдэд хүргэж 7200 иргэдээс хандалт авсан байна<br><br>**ҮР ДҮН:** Хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх мэдээллийг олон дагагчтай группт байршуулж нийт 117200 хүн хандсан. Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн 3000 гишүүнтэй фейсбүүк групп болон веб хуудасны “Эмч зөвлөж байна” буланд хавдраас урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж, мэдээллийг сар бүр байршуулсан, видео мэдээлэл 4,9 сая хандалт авсан. | |
| 43 | **БСТ 1.1.8, 2.1.3.**<br>Умайн хүзүүний ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын ач холбогдлыг иргэдэд мэдээлэл ухуулга, арга хэмжээг зохион байгуулна. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Түгээсэн мэдээллийн тоо | 1907 гаруй мэдээллийг боловсруулж түгээсэн. | Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сурталчилгааны баримтын цомгийг ашиглан хэрэгжүүлсэн байна. | Тус төвөөр үйлчлүүлж буй иргэдэд “Умайн хүзүүний ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын ач холбогдол” сэдвээр нийт 17 удаа сургалт зохион байгуулж 1900 хүн, сурталчилгааг 98 удаа хийж, 25900 хүн хамруулж 4 төрлийн 5000 ширхэг сурталчилгааны материал тарааж ухуулга хийсэн. 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулж нийт 900 хүн хамруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Умайн хоргүй хавдрын тухай иргэдэд зориулсан контентийг фейсбүүк хуудсаар дамжуулан 9800 иргэдийн хандалт авсан байна.<br>Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх урьдчилан сэргийлэх үзлэгт иргэдийг уриалсан мэдээлэл сошиалаар түгээсэн.<br><br>**ҮР ДҮН:** "Умайн хүзүүний ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын ач холбогдол" сэдвээр нийт 17 удаа сургалт зохион байгуулж, 1900 хүн хамруулж, сурталчилгааг 98 удаа хийж, 25900 хүн хамруулж, 4 төрлийн 5000 ширхэг сурталчилгааны материал тарааж ухуулга хийсэн. 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулж нийт 900 хүн хамруулсан. | |
| 44 | **БСТ 1.2.5, 1.2.6, 2.1.3.** Өсвөр насны эрэгтэй хүүхдийн нөхөн үржихүй, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, осол гэмтлээс сэргийлэх МСС олон нийтийн | 20.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Боловсруулж түгээсэн мэдээллийн тоо | 13800 гаруй мэдээллийг боловсруулж түгээсэн | Өсвөр насны эрэгтэй хүүхдэд зориулсан цуврал контент хийж түгээсэн байна. | Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "ӨСВӨР ҮЕИЙНХНИЙГ СОНСЪЁ, ОЙЛГОЁ" сэдэвт 2025 оны 04 дүгээр сарын 15-аас 05 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулагдах 1 сарын аяны хүрээнд өсвөр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахим сүлжээгээр тогтмол хийнэ. | | | | | насныханд тулгамдаж буй эрүүл мэндийн асуудлуудын талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, анхаарлыг хандуулах, өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор үе шаттай арга хэмжээг төлөвлөн 4 дүгээр сарын 15-ны өдөр аяны нээлтийг зохион байгуулж тус төвийн амбулаторид үйлчлүүлж байгаа өсвөр насныхан, ар гэрийнхэнд “Өсвөр үеийнхэн тэдний онцлог, хэрэгцээ” сэдвээр сургалт мэдээлэл, гарын авлага өгч ажилласан. Үйл ажиллагаанд нийт 128 хүн хамрагдаж 3 төрлийн сурталчилгааны материал 250 ширхэгийг тарааж мэдээлэл өгсөн.<br>Хан-Уул дүүргийн 21-р хорооны 161, 163, 89-р сургуулийн 10,11,12-р ангийн 450 хүүхдүүдэд 4 сарын 23, 24-ны өдрүүдэд “Зөв, зохистой хооллолт, идэвхтэй дасгал хөдөлгөөн”, ”Сэтгэцийн эрүүл мэнд, хорт бодисын хэрэглээ, хүчирхийллийн улмаас тохиолдож буй бэрхшээл” | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэдвээр эрүүл мэндийн нийгмийн ажилтан, хоол зүйч, дотоод сургалт хариуцсан ажилтан нар тус сургуулийн эмчтэй хамтран зохион байгуулсан. Сургалтанд хамрагдсан хүүхдүүдийг бүлгээр ажиллуулж санал бодлыг нь сонсож, сонирхсон асуултанд нь хариулж тэдэнд мэдээлэл өгч мэдлэгийг нь дээшлүүлсэн үйл ажиллагаа болсон. Олон нийтийн цахим сүлжээгээр сар бүр мэдээлэл байршуулсан.<br>•Төвийн цахим хуудас,<br>•Хан-Уул эрүүл мэндийн төв,<br>•Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп,<br>•Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп,<br>•Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп,<br>•Буянт Ухаа-2 хороолол,<br>•Шүрт хотхоны групп,<br>•Өлзийт хорооллын оршин суугчдын групп<br>•Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 45860 хүн хандалт хийсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **ҮР ДҮН:** амбулаториор үйлчлүүлж байгаа өсвөр насныхан, ар гэрийнхэнд “Өсвөр үеийнхэн тэдний онцлог, хэрэгцээ” сэдвээр сургалт мэдээллийг 128 хүнд, 3 төрлийн сурталчилгааны материал, гарын авлагыг 250 ширхэгийг тарааж, Хан-Уул дүүргийн 21-р хорооны 161, 163, 89-р сургуулийн 10,11,12-р ангийн 450 хүүхдэд “Зөв, зохистой хооллолт, идэвхтэй дасгал хөдөлгөөн”, ”Сэтгэцийн эрүүл мэнд, хорт бодисын хэрэглээ, хүчирхийллийн улмаас тохиолдож буй бэрхшээл” сэдвээр эрүүл мэндийн нийгмийн ажилтан, хоол зүйч, дотоод сургалт хариуцсан ажилтан нар тус сургуулийн эмчтэй хамтран зохион байгуулсан. Мэдээллийг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 45860 хүн хандалт хийсэн. | |
| 45 | **БСТ 1.1.7, 3.3.2, 5.1.1.** БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна. | 10.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо | БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх 50 сургалт зохион байгуулж, 2540 гаруй хүн хамрагдсан. | БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалтанд хамрагдаж, гэр бүл төлөвлөлтийн | Хэвтэн эмчлүүлэх тасаг дээр БЗДХ-с сэргийлэх сургалт нийт 548 эмэгтэйчүүдэд 3 цаг 50 минутын сургалт хийгдсэн. Зөвлөх поликлиникийн тасгаар нийт 18 цагийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангагдаагүй хэрэгцээ буурна. | сургалт давхардсан тоогоор 5680 иргэдэд хийсэн.<br>БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх сурталчилгааг үйлчлүүлж буй иргэдэд нийт 72 удаа явуулж 5000 ширхэг 9 төрлийн сурталчилгааны материал тарааж нийт 18270 хүнд зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан. Өсвөр насныханыг сонсъё, ойлгоё аяны хүрээнд ХУД-ийн 114, 161, 163, 118-р сургуулийн 10-12р ангийн 680 гаруй сурагчдад “Өсвөр насны сэтгэл зүйн онцлог”, “Бие махбодид гарах өөрчлөлт, бэлгийн боловсрол”, “Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх” зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийж, сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг тус сургуулийн эмч, нийгмийн ажилтан нар хамтран зохион байгуулсан.<br>Өөрийн пэйж хуудсаар дамжуулан нийт 47 удаагийн давтамжтай 22 төрлийн мэдээллийг байршуулж 17000 хүн хандалт хийсэн байна.<br><br>**ҮР ДҮН:** Сургалт сурталчилгааг 42,178 хүнд хүргэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | **БСТ 2.1.1.** Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна. | ЭМЯ, Олон улсын байгууллага, ЭМДСангийн санхүүжилт | Батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг батлуулж 3 резидент эмч төгсөж, 37 резидент эмч суралцаж байна. | Сургалтын үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Төгсөлтийн дараах сургалтанд эх барих эмэгтэйчүүд судлал болон Хүүхэд судлалаар нийт 38 резидент эмч нар суралцаж байна. Үүнд:<br>-2022-2024 оны хичээлийн жилд Эх барих эмэгтэйчүүд судлалаар 3 эмч суралцаж төгссөн.<br>-2023-2025 оны хичээлийн жилд хүүхэд судлалаар 6, эх барих эмэгтэйчүүд судлалаар 6 резидент эмч суралцаж төгссөн.<br>-2024-2026 оны хичээлийн жилд эх барих эмэгтэйчүүд судлалаар 10, Хүүхэд судлалаар 15 резидент элсэн орж төвийн хэмжээнд нийтдээ хүүхэд судлалаар нийт 28, эх барих эмэгтэйчүүд судлалаар 10 хүүхэд суралцаж байна<br><br>**ҮР ДҮН:** Төгсөлтийн дараах сургалтанд эх барих эмэгтэйчүүд судлал болон Хүүхэд судлалаар нийт 38 резидент эмч нар суралцаж байна. | 100% |
| 47 | **БСТ 1.1.7, 2.1.4**. Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн гардан тусламж үзүүлэх | 130.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Ашиглалтад орсон сургалтын төв | Бэлтгэл ажил 100% хэрэгжсэн. | Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн гардан тусламж | Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн гардан тусламж үзүүлэх дууриамал сургалтын төвийг байгуулж, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дуураймал сургалтын төвийг үе шаттайгаар байгуулна. | | | | үзүүлэх дуураймал сургалтын төв байгуулсан байна. | үйлдлийн муляжууд худалдан авсан.<br>Сургалтын өрөө гарган дараах муляжуудыг ашиглан нийт 12 удаагийн сургалт орсон, 1 удаагийн АСТ тэмцээн зохион байгуулсан.<br>Ашиглаж буй сургалтын мульяжууд:<br>• Эмэгтэйн бүтэн биеийн модель 1ш<br>• Төрөлтийн эх ургийн модель 1ш<br>• Судас тарианы модель 3ш<br>• Мэс заслын оёдлын модель 10 ком<br>• Умайн анатомын модель 1 ком<br>• Жирэмсний модель 1 ком<br>• Нярайн ерөнхий модель 1 ком<br>• Хярзангийн оёдлын модель 5 ком<br>• Хэвлийн дурангийн сургалтын 2 ком<br>• Төрөлтийн манекан 1ш<br><br>**ҮР ДҮН:** Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн гардан тусламж үзүүлэх дуураймал сургалтын төвийг байгуулж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10 муляжыг ашиглан 12 удаа сургалт зохион байгуулсан. | |
| 48 | **БСТ 1.1.7.**<br>“Эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах тусламж үйлчилгээг сайжруулах” сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулна. | Олон улсын байгууллага, ЭМДСангийн санхүүжилт | Сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагууд ын тоо | Орон нутгийн 198 эмч хамрагдсан. | Орон нутгийн 250 эмчийг хамруулна. | 1.“Эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах тусламж үйлчилгээг сайжруулах” сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 170 гаруй эмч, сувилагч, бусад мэргэжилтэн нар хамрагдсан.<br>2. УБ хотын амаржих газрууд, эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгүүдийн нярайн эмч, сувилагч, бусад мэргэжилтэн нарт “Нярайн цогц скрининг шинжилгээг нутагшуулах нь” чадавхжуулах 5 өдрийн сургалтыг зохион байгуулж нийт 60, тус төвөөс 11 нярайн эмч болон резидент 13, нийт 24 эмч нар хамрагдаж батламж гардуулан өгсөн.<br>3.ЭМС-н А/292 тоот тушаал “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”болон ЭМС-н А/244 тоот тушаалд заасан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний тушаалыг баримтлан 2025.05.29-2025.05.30-ны өдрүүдэд Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-д "ЖИРЭМСНИЙ БҮЛГИЙН ХЯНАЛТЫН | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | СУРГАГЧ БАГШ НАР" бэлдэх сургалт зохион байгуулагдлаа. Нийт 2 хоногийн сургалтанд Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн ажилчид, Хан-Уул, Сонгино хайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нар хамрагдав.<br>4. 2025 оны 04 сард ЭНЭҮТ болон ЭХЭМҮТ-ийн эмч нар ХУД-ийн 25 өрхийн эмнэлгийн эмч нар “Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгийн оношилгооны зарчмууд” сэдэвт сургалтыг ЭНЭҮТ-д зохион байгуулж өрхийн эмнэлгийн 56 эмч хамрагдсан ба АУ-ны доктор, клиникийн профессор, Улаанбаатр бүсийн менежер, ЭМЯ-ны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлөийн дарга, ХАТТАН тэргүүн, ЭНЭҮТ-ийн зөвлөх эмч Ш.Энхтөр “Хүүхдийн амь тэнссэн төлөвийн тусламжийн зарим асуудлууд” сэдвээр, АУ-ны магистр, клиникийн профессор, зөвлөх зэргийн эмч, ЭХЭМҮТ-ийн Нярайн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч Ч.Нарантуяа “Нярайн эмгэгүүд”, АУ-ны магистр, клиникийн профессор, зөвлөх зэргийн эмч, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн чих, хамар, хоолойн мэс заслын тасгийн эрхлэгч Б.Дэлгэрмаа “Хүүхдэд зонхилон тохиолдох чих хамар хоолойн эмгэгүүд”, АУ-ны магистр, клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч, ЭНЭҮТ-ийн хүүхдийн мэс заслын эмч Ж.Адьясүрэн “Хүүхдэд зонхилон тохиолдох мэс заслын эмгэгүүд” сэдэвт сургалтыг орсон.<br><br>**ҮР ДҮН:** ЭМЯ-ны дэргэдэх Эх барих эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, гишүүнээр тус төвөөс 5 эмч нар ажилладаг тул эх, хүүхдийн өвчлөл, эндэглийг бууруулах чиглэлээр ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ, НЭМҮТ, ЭХЭМҮТ-тэй хамтран улсын хэмжээний сургалтыг цахимаар болон танхимаар 20 гаруй удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 5000 орчим эмч, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. | |
| 49 | **БСТ 1.2.2.** “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж” сургалтыг үндэсний хэмжээнд үе шаттай зохион байгуулна. | | Сургалтад хамрагдсан эмч мэргэжилтнүүдийн тоо | 20 | 80 | Эмнэлзүйн сургагч багшаар нийт 12 хүүхдийн эмч бэлтгэгдсэн ба орон нутаг, дүүргийн эмч нарт “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж” сургалтыг зохион байгуулсан. Монголын Хүүхдийн Амь Тэнссэн Төлөвийн Анагаахын Нийгэмлэгтэй хамтран “Хүүхдийн амь тэнссэн үеийн суурь тусламж”, “Хүүхдийн амь тэнссэн үеийн лавшруулсан тусламж” дотоодын сургалтыг зохион байгуулсан. Төвийн хэмжээнд 112 ажилтанд яаралтай тусламжын сургалтыг “Түргэн тусламжийн яаралтай нийгэмлэг”-тэй хамтран зохион байгуулсан бөгөөд сургалт онол, дадлага, бодит тохиолдол дээр ажиллах гэсэн хэсэгтэйгээр амжилттай зохион байгуулагдаж олон улсын сертификат олгосон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **ҮР ДҮН:** “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж” сургалтыг Монголын Хүүхдийн Амь Тэнссэн Төлөвийн Анагаахын Нийгэмлэгтэй хамтран ЭНЭҮТ, ЭХЭМҮТ-д 2 удаа зохион байгуулж, аймаг, дүүргийн 80 гаруй хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмч нарыг хамруулсан. | |
| 50 | **БСТ 1.2.9.** Амилуулах гүнзгийрүүлсэн тусламжийн (PALS, ALS) сургагч багшийг бэлтгэнэ. | Олон улсын байгууллага, Мэргэжлийн нийгэмлэг холбоо, ЭМДСангийн санхүүжилт | Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо | 8 | 9 | Хонгконг улстай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд тус эмнэлгийн эмч нар ЭНЭҮТ-д ирж хүүхдэд үзүүлэх амилуулах гүнзгийрүүлсэн тусламжийн PALS (pediatric advanced life support), ALS (advanced life support)-ын сургагч багш бэлтгэх дадлага сургалтыг зохион байгуулна.<br><br>**ҮР ДҮН:** 2025 оны 12 сард ЭМХТ-тэй хамтран зохион байгуулж, үндэсний хэмжээнд 40 сургагч багшийг бэлтгэнэ. | 80% |
| 51 | **БСТ 1.1.7, 1.2.8.** Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх үндэсний | ЭМДСангийн санхүүжилт | Хамрагдсан эмч мэргэжилтний тоо | 7 | 8 | Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх үндэсний хэмжээний сургагч багш бэлгэх сургалтыг 2025.05.08-10-ны хооронд Дархан-Уул | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний сургагч багш сургана. | | | | | аймагт ЭМЯ-наас зохион байгуулж тус төвөөс нярайн 4 эмч хамрагдаж бэлтгэгдсэн. Мөн Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх үндэсний хэмжээний сургагч багш бэлтгэх сургалтанд нярайн эмч Э.Тунгалаг, Отгонзаяа, Ринчин нар хамрагдсан.<br><br>**ҮР ДҮН:** Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх үндэсний хэмжээний сургагч багшаар 8 эмч ажилладаг бөгөөд 3 эмч нэмэгдсэн. | |
| 52 | **БСТ 2.1.1, 2.2.2**<br>Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох сургалтанд хамруулна. | 40.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Сургалтанд хамрагдсан эмч нарын тоо | Энэтхэг, Швейцар, ОХУ, Солонгос зэрэг улсуудад мэргэжил дээшлүүлэх сургалтанд 50 эмч мэргэжилтэнг хамруулсан. | Гадаад улсуудад эмч эмнэлгийн мэргэжилтэнг хамруулна. | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025-2026 оны хичээлийн жилд мэргэжил дээшлүүлэх, төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр 7 эмч 4 сувилагч, тусгай мэргэжилтэнг мэргэжил олгох сургалтад хамруулсан.<br>Солонгос-2 Хятад-1 улсад эмнэлгийн мэргэжилтэнг 3-7 хоногийн сургалтад хамруулан цалинг олгож ажилласан. Их эмчийн мэргэшүүлэх сургалт удирдах эмнэлзүйн сургагч багшийн сургалтыг ирэх 9 сард үе шаттайгаар бэлтгэнэ. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -БНСУ-ын Чам Чуван эмнэлэгтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хүүхдийн эмч нарыг богино хугацааны дадлага сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>-ОХУ-ын Эрүүлийг хамгаалах яамнаас эх, нярай, 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах тогтвортой хөгжлийн хүрээнд жил бүр зохион байгуулдаг “Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх зарчмууд” сэдэвт сургалтад хүүхдийн эмч нарын 2 эмч хамрагдсан.<br>ОХУ Эрүүлийг хамгаалах яамны харьяа Эх барих, эмэгтэйчүүд, перинатологийн анагаах ухааны үндэсний төвд 2025 оны 10 сарын 4-өөс 16-ны өдрүүдэд ЭБЭЭ зохицуулагч эмч Б.Цэнгэл Эх барих, эмэгтэйчүүд”, “Нярайн эмгэг судлал”, “Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах” зэрэг сэдвүүдийн хүрээнд сургалтанд хамрагдсан. Мөн тус төвд Төрсний дараах тасгын эрхлэгч А.Баянбаатар, Нярайн эмч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ж.Ринчин, Эрчим эмчилгээний эмч С.Алимантуяа нар 20250 оны 10-р сарын 18-11 сарын 2 өдрүүдэд “Хүүхдийн халдварт өвчний орчин үеийн чиг хандлага сэдэвт сургалтанд суусан байна.<br><br>**ҮР ДҮН:** БНСУ, ОХУ, Хятад улсад нийт 19 эмч, эмнэлгийн мэргэжилтэн богино хугацааны сургалтад хамрагдсан. | |
| Зорилт 2.2: Гадаад харилцааг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 53 | **БСТ 2.2.1, 2.2.2.** Олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | ДЭМБ, НҮБ-ХАС, НҮБ-ХС, Жайка төсөл | Батлагдсан төсөл, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | Төсөл батлагдаж, АНУ, БНСУ, ОХУ, Франц улсуудад 12 сургалтанд эмч мэргэжилтэнг хамруулсан. | Хамтран ажиллах олон улсын байгууллагуудын тоог нэмэгдүүлнэ. | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат болон **UNICEF**-ийн суурин төлөөлөгч, **ORBIS** ХХК-ийн төлөөлөгчид компьютер, эмнэлгийн тоног төхөөрөмж гардуулан өгч, нийслэлийн амаржих газрууд, эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгүүдийн нярайн эмч, сувилагч, бусад мэргэжилтэн нарт “Нярайн цогц скрининг шинжилгээг нутагшуулах нь” чадавхжуулах 5 өдрийн сургалтыг зохион байгуулж нийт 60, тус төвөөс 11 нярайн эмч болон резидент 13, нийт 24 эмч нар хамрагдаж батламж гардуулан өгсөн. | 95% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэгээс Словени** улсын Портороз хотод 2025 оны 2 сарын 28-с 2025 оны 3 сарын 1-ны хооронд зохион байгуулсан Integrative Medical Aproach to Allergy and Atopic Dermatitis сэдэвт сургалт болон хэлэлцүүлэгт Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвйн Хүүхдийн Дотрын тасгийн эрхлэгч Э.Намуун Монгол улсаас нийт 3 эмчийн хамт оролцсон. Тус сургалтанд нийт 15 улс орны 300 гаруй хүүхдийн эмч, харшлын эмч арьсны эмч нар хамрагдсан ба Монгол улсаа төлөөлөн хүүхдийн харшлын өвчний хэлэлцүүлэгт амжилттай оролцож, **Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэгийн** Ерөнхийлөгч Массимо Мантованитай гэрээ хийж дараагийн удаа зохион байгуулагдах хэлэлцүүлэгт Монгол улсаас эмч нарыг цахим хэлбэрээр оролцуулахаар тохиролцсон. **Монтенегро улсад** 2025 оны 6 сарын 12-нд Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэгээс зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдах Хөхний сүүний ач тус сэдэвт сургалт болон хэлэлцүүлэгт Эх, нярай эмэгтэйчүүдий үндэсний төвийн эмч, ЭЭДЗ нар хамрагдсан. Тус хэлэлцүүлэгт 2025 оны 2 сард Словени улсад болсон Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулсан сургалт дээр нийгэмлэгийн Ерөнхийлөгчтэй хийсэн хэлэлцээрийн дагуу Монгол улсаас нийт 25-30 эмч нарыг цахим хэлэлцүүлэгт нээлттэй оролцуулахаар болсон.<br>“Нярайд Амьдрал Бэлэглэе-2” сэдэвт сургалт 2025 оны 5 сарын 8-с 10-ны өдрүүдийн хооронд Дархан хотод зохион байгуулагдсан. Нийт 17 аймаг, нийслэл Улаанбаатар хотоос 50 эмч, мэргэжилтэн хамрагдсан. Тус сургалт нь Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Монголын Хүүхдийн Амь Тэнссэн Төлөвийн Анагаахын Нийгэмлэгээс **АНУ-ын хүүхдийн эмч** нартай хамтран зохион байгуулсан. Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвөөс нийт 3 эмч, нярайн эмч С.Оюун-Эрдэнэ, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Б.Эрдэнэчимэг, хүүхдийн эмч Э.Намуун нар амжилттай оролцсон. Хүүхдийн эмч Э.Намуун, нярайн эмч С.Оюун-Эрдэнэ нар 3 өдрийн турш нийт 12 лекцийг АНУ-с ирсэн 4 хүүхэд нярайн эмчийн хамт орсон ба англи хэлнээс монгол хэлнээ сургалтын үед орчуулга хийн оролцсон<br>“Төрсний дараах цус алдалтын үед ташааны дотор артерийн судсыг боох мэс засал эмчилгээний үр дүн” болон “Умайн хүзүүний дутмагшил эхчүүдийг дагаж судалсан судалгааны дүн” судалгааны ажлууд FIGO 2025 олон улсын хуралд ханын илтгэлээр тус тус шалгарч ЭБЭЭ-н эмчилгээ эрхэлсэн дэд захирал Ж.Оюунцэцэг **ӨАБНУ-д** ханын илтгэлээ амжилттай хэлэлцүүлсэн.<br>Лабораторийн эрхлэгч Д.Орлом, лабораторийн эмч Э.Уганцэцэг, У.Намуунбаяр нар 2025 оны 10 сарын 29-нөөс 10 сарын 31-ний өдрүүдэд **Солонгос улсын** Инчеон хотод “Лабораторийн Анагаах Ухааны Конгресс ба Үзэсгэлэн, Солонгосын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Лабораторийн Анагаах Ухааны Нийгэмлэгийн 66 дахь Жилийн Чуулган (LMCE 2025 Laboratory Medicine Congress & Exhibition & KSLM 66th Annual Meeting)” – д байгууллагаа төлөөлөн “Detection of viral and bacterial pathogens in children hospitalized for severe acute respiratory infections” сэдэвт ханын илтгэлээр амжилттай оролцов.<br>Нярайн тасгын эрхлэгч Ч.Батням **Япон улсын** эх нярайн эмнэлэгт "Нярайн амилуулах суурь тусламж" сэдэвт сургалтанд 2025 оны 11 сарын 30-12 сарын 5 хооронд амжилттай хамрагдсан.<br><br>**ҮР ДҮН:** UNICEF, ORBIS, Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэг, Словени Монтенегро улс, АНУ-ын хүүхдийн эмч нарын нийгэмлэг, Өмнөд Африкийн Бүгд найрамдах Улс, БНСУ, Япон улсын эмч нартай хамтран сургалт, хэлэлцүүлэг, илтгэл хэлэлцүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | **БСТ 2.2.1, 2.2.2.** Дотоодын болон олон улсын мэргэжлийн нийгэмлэгүүд, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг эрчимжүүлнэ. | - | Хамтран ажилласан ТББ, нийгэмлэгийн тоо | Нийт 8 төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. | Хамтын ажиллагааг 100% нэмэгдүүлж ажиллана. | -ЭМЯ-ны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл<br>-Хүүхдийн амь тэнссэн төлөвийн анагаахын нийгэмлэгтэй хамтран хүүхдийн амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээгээр цуврал лекцыг ЭНЭҮТ-ийн эмч нар, ХУД, СХД-ийн Хүүхдийн эмч нарт хүүхдийн резидент эмч нарт зохион байгуулсан.<br>Хүрээ Ротари клубын дэмжлэгтэйгээр Нярайн эмгэг судлалын тасагт 300 сая төгрөгийн өртөг бүхий 360 фото шарлагын аппарат,-1 суурин ЭХО аппарат-1, зөөврийн ЭХО аппарат-1, нярайн bubble срар аппарат-1, билиметр-3, зөөврийн пульсоксиметр-3 ширхэгийг тус тус хандивласан.<br>Гадаад орны хамтын ажиллагааны 2025 оны эхний хагас жилийн байдлаар БНСУ-ын Хүрээ ротари клубтай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд нярайн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжүүд хүлээн авч Хонконгын Туул ротари клуб, Энэтхэг Монголын эрүүл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлтийн дараах үр дүн бичсэн- 78,7%<br><br>**ДҮГНЭЛТ:** ЭМТҮЧАБА нь 4 төрлийн ижил мэргэжилтний үнэлгээний хяналтыг, 2925 үйлдэлд, 137 хяналтын хуудсаар хийсэн байна. MNS4621:2008 ТҮГЭЭМЭЛ ҮЙЛДЛИЙН СТАНДАРТЫН мөрдөлт -81.93%. 2024 оны стандарт мөрдөлтийн үнэлгээнээс 6.3 %-иар нэмэгдсэн.<br>ЭМТҮЧАБА нь үйл ажиллагааны 12 чиглэлээр тасгуудад дотоод хяналт үнэлгээ хийгдсэн.<br>• Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал- 2 чиглэлээр /яаралтай тусламжийн эм тарианы бэлэн байдал, эм тариа андуурагдах эрсдэл/<br>• Нөөцийн хангамж- 2 чиглэлээр /Халдваргүйтгэлийн бодисын хангалт, өртөлтийн цомгийн бүрдэл /<br>• Цэвэрлэгээ үйлчилгээний байдал- 2 чиглэлээр /Өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ/<br>• Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал– 1 чиглэлээр /Тоног төхөөрөмжийн ашиглалтын бүртгэл/<br>• Анхан шатны бичиг баримт хөтлөлт- 3 чиглэлээр- /Халдваргүйтгэлийн бодис найруулсан бүртгэл, ээлж хүлээлцэх бүртгэл, анхааруулах үйлчлүүлэгчийг хүлээлцэх бүртгэл/<br>• Ажлын байрны бэлэн байдал - 2 чиглэлээр /сувилагчийн аюулгүй хайрцагны бэлэн байдал, эм түгээлт/<br>• Ээлж хүлээлцэх– анхаарал татсан үйлчлүүлэгч хүлээлцэх, тасгаа хүлээлцэх байдалд хяналт үнэлгээ хийж 12 асуудал, тохиолдлыг ажлын байранд нь засуулж, хангамж нөөцтэй холбоотой асуудлыг шийдүүллээ.<br>Түгээмэл үйлдлийн стандарт сургалтын удирдамж төлөвлөгөөг эмчилгээ эрхэлсэн дэд захиралаар батлуулан хуваарийн дагуу тасаг нэгжээр онол болон гардан сургалтыг ЭБЭЭ-ХАЯТТ, ХЭ-ХАЯТТ, ЭЭСТ, Хүүхдийн амьсгалын тасаг, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дутуу тээлтийн тасаг, Хүүхдийн дотрын эмгэг судлаын тасаг, ЖЭЭТ, Хүүхдийн чих хамар хоолойн тасгуудад төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.<br>Эх баригч, сувиалгч нарыг “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах” талаар сургалтын өмнөх онолын мэдлэгийг үнэлэхэд 58.6-88.2%-тай байв. Сургалтын дараа 82.1-98.4% болж сайжирсан байна. Тарилгын аюулгүй байдлын стандартыг үнэлэхэд 33.8-80.8%-тай байв. Сургалтын дараа 89.4-97.6% хүртэл сайжирсан байна.<br>Тасгийн менежерүүдийн мэдлэг ур чадварыг ХНА, ЭМТҮЧАБА, Сувилахуйн алба хамтран үнэлэхэд “Үйлчүүлэгчийг зөв танин тодруулах”, “Тарилгын стандарт”-ыг үнэлэхэд 55.6-92.6%-тай үнэлэгдсэн байна.<br>Лабораторийн шинжилгээнд сорьц авах, зөөвөрлөх аргачлал сэдэвт сургалтын хөтөлбөр удирдамжийг ЭНЭҮТ-ийн ЭБЭЭ-ийн эмчилгээ эрхэлсэн дэд захирлуудаар батлуулан хөтөлбөрийн дагуу сургалтыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгууллаа. Тус сургалтыг 3-4 удаа зохион байгуулсан боловч лаборатори шинжилгээтэй холбоотой үл тохирол бүртгэгдсээр сайжрахгүй байгаа тул энэхүү сургалтыг дахин зохион байгуулж байна. Сургалтын өмнөх сорилыг авахад хүүхдийн эмнэлгийн мэргэжилтэн-26.3%, ЭБЭЭ-ийн мэргэжилтэн-36.2% тай үнэлэгдсэн байна. сургалтын дараах сорилд нийт 78 эмнэлгийн мэргэжилтэн 81.4-96.1%-тай үнэлэгдсэн байна. Лабораторийн шинжилгээний сорьц авах, тээвэрлэхтэй холбоотой үл тохирлыг лабораторийн тасгийн ахлах лаборант 7 хоног бүрээр гаргаж, сар бүрээр нэгтгэж, засагдаж болох үл тохирлыг тухай бүрт нь залруулж, хариу арга хэмжээ авч ажиллалаа.<br>Нэгдсэн Лабораторийн тасгийн эрхлэгч "Лаборатори шинжилгээнд сорьц авах аргачлал, Тээвэрлэх аргачлал, Дагалдах хуудас болон бар код наах" зэргээр мэдээлэл сургалтыг эх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баригч, сувилагч нарт зохион байгууллаа.<br>Яаралтай тусламжаар ирсэн үйлчлүүлэгчийг эрэмбэлэн ангилах талаар ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж ажиллалаа.<br>Эх барихын эмнэлэг болон Хүүхдийн эмнэлгийн ХАЯТусламжийн бэлэн байдлыг үнэлэх хяналтын хуудсыг боловсруулан тасаг нэгжид ээлж хүлээлцэх бүрд бүртгэж хүлээлцэж байна.<br>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот тушаалын хэрэгжилтийг сайжруулах, анхан шатны маягт хөтлөлтийг бүрэн үнэн зөв хөтөлж сургах онол болон дадлагат давтан сургалтын хөтөлбөр удирдамжийг ЭНЭҮТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захиралаар батлуулан хөтөлбөрийн дагуу онол болон дадлага сургалтыг нийт эх баригч, сувилагч нарт зохион байгууллаа.<br>Сувилахуйн алба, сургалт гадаад харилцааны алба нар хамтран “АНХАН ШАТНЫ БҮРТГЭЛ МАЯГТЫГ САЙЖРУУЛЬЯ“ давтан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтыг зохион байгуулж байна. Сургалтыг 3 өдрийн турш онол болон дадлага хэлбэрээр явагдсан.<br>**ДҮГНЭЛТ:** Нийт тасгуудад өмнөх алдаа давталд 50-70% буурсан. Тухайн өдрийн жижүүр эх баригч, сувилагч нар өөрийн карте системээр нэвтэрч эм тариаг зарлагдахгүй бол нэг хүн 48, 72 цаг ажилласан харагдаж байна. Мөн эмийн эмчилгээний хуудас дээр уян зүү тавьсан хэрнээ зарлагдаагүй, Сувилахуйн төлөвлөгөө хэрэгжилт дээр #29 онош тавьсан боловч уян зүүтэй холбоотой халдварын эрсдлийн талаар зөвлөгөө байхгүй, Судасны гуурсны халдварыг шинж тэмдэгээр тандах хуудас бөглөөгүй байна.<br>Тасгуудын ЭМТҮЧАБ-ын баг нь дараах байдлаар дотоод хяналт үнэлгээ хийсэн. 2025 оны 1, 2-р улирлын Эхийн ноцтой хүндрэл-2, нярайн эндэгдэл-1, амьгүй төрөлт-3 тохиолдол бүртгэгдэж, ЭМС-ын 2023 оны А/447 тоот тушаалын дагуу эмгэг судлалын хурлыг нийт эх барих, эмэгтэйчүүдийн эмч, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | резиндент эмч нарыг оролцуулан нийт-3 удаа зохион байгуулсан.<br>Хяналтгүй жирэмсэн-11, гэрийн төрөлт-5, эгэмний хугарал-21 удаа, анхаарал татсан-1 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Эмчилгээ үйлчилгээний стандарт мөрдөлтөнд хяналт тавин, тусламж үйлчилгээнд гарсан үл тохирол, тохиолдлыг ЭМС-ын 2019 оны А/566, 2023 оны А/292, 2024 оны 03 сарын 05 нд батлагдсан А/112 тоот тушаалын дагуу “ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээллэх, хариу арга хэмжээ авч ажиллаж байна.<br>Тасгууд дараах зүйлсийг өдөр тутамдаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:<br>• Тасгийн эрхлэгч болон тасгийн эрхлэгч эмч нарын тойрон үзлэг 7 хоног бүрийн мягмар гаригт<br>• Түгээмэл үйлдлийн стандартын MNS4621-2008 хэрэгжилт<br>• ЭМС-ийн 2019 оны А/406 тоот тушаалын хэрэгжилт | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дотоодын хяналт шалгалт мониторинг тогтмол хийгдэж хэвшсэн. Үүнд:<br>• Өвчтний түүх бичилтийн стандарт<br>• Түгээмэл үйлдлийн стандарт MNS4621:2008<br>• Ижил мэргэжилтний үзлэг шалгалт<br>• Гар угаалт (ЭМС-н 2019 оны А/537 тоот тушаал)<br>• Эмнэлгийн гаралтай хог хаягдлын ангилж, хадгалж, устгах заавар (ЭМС-ын 2025 оны А/193, А/173 тоот тушаал)<br>• Ажилбарын өрөөний бэлэн байдал /chek list/<br>• Тасгийн яаралтай эмийн хяналтын хуудас<br>• Мизопростол, ажилбар хийсэн эхийн хяналтын хуудас<br>• Халдваргүйжүүлэлтийн хяналтын хуудас<br>Эмийн аюулгүй байдлын хангаж ажиллан хяналт тавих. Үүнд:<br>• Антибиотикийн зохистой хэрэглээ<br>• Эмч эмнэлгийн мэргэжилтний эмийн хэрэглээний мэдлэгийг сайжруулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сар бүр эм зүйн албанд Тасгийн захиалга, эмнэлгийн хэрэгслийн захиалга хийж, зарлагын тайланг гарган эмийн орлого зарлага дээр хяналт тавин ажиллаж байна .<br>Антибиотикийн зохистой хэрэглээг хянаж ажиллаж байна.<br>Эмч эмнэлгийн мэргэжилтний эмийн хэрэглээний мэдлэгийг сайжруулах тал дээр онцгой анхааран ажиллаж байна.<br>Хугацаат эмийн самбарын үйл ажиллагааг тогтмол шинэчилж, хугацаа дуусахаас 1 сарын өмнө эм эмнэлгийн хэрэгслийг эм зүйн албанд буцаалт хийж ажиллаж байна.<br>Эмнэлгийн мэргэжилтнийг цахим түүхийн анхан шатны бичиг баримт хөтлөлтийг тогтмол сайжруулах зорилгоор:<br>Тасгийн ахлах эх баригч өдөр бүр цахим түүх бичилтийг хяналт хийж, гарсан дутагдлыг тухай бүрт нь засуулж, чиглүүлэн ажиллаж байна.<br>Цахим түүх бичилтэнд гарч буй тохиолдол бүрт дүн шинжилгээ хийж дахин алдаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гаргахгүй байх талаар заавар зөвлөгөө өгөн ажиллаж байна.<br>Төвийн дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмыг Төвийн Ерөнхий захирлын 2023 оны А/25 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.<br>Сувилахуйн алба, Соёл үйлчилгээний алба, халдварын сэргийлэлт хяналт тандалтын алба, Хоол үйлдвэрлэлийн тасаг, эдийн засаг төлөвлөлт статистикийн алба, лабораторийн тасаг, эм зүйн алба, ХЭ болон ЭБЭЭ-ийн 14 тасаг, эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасаг, дүрс оншилгооны тасгуудын үйл ажиллагаанд дотоодын хяналт үнэлгээг хяналтын хуудсаар график хуваарийн дагуу хийж ажилласан байна.<br>Тус төвд нийт 230 нэр төрлийн давхардсан тоогоор 1535 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна<br>Эмнэлгийн тоног төхөөрөмжтэй холбоотой хяналт үнэлгээг тогтмол хийж хэвшүүлсэн. Төвийн хэмжээнд нийт 22 тасгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт аюулгүй ажиллагааны заавarчилгаагаар бүрэн хангaн, тоног төхөөрөмжийн техникийн эргэлт үйлчилгээг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>• Эмнэлгийн тоног төхөөрөмж /ЭТТ/ засвар үйлчилгээ<br>• Шинээр ЭТТ хүлээн авах, байрлуулах, суурьлуулах<br>• ЭТТ ашиглах сургалт аюулгүй ажиллагааны заавар өгөх<br>• ЭТТ-тэй холбоотой судалгаа бичиг баримтыг бүрдүүлэх<br>• ЭТТ-ийн мэдээллийн сан бүрдүүлэх<br>• ЭТТ агуулах<br>• Шинээр захиалах тоног төхөөрөмжийн үнийн судалгаа хийх<br>Тендер, судалгаа,албан бичиг, баримт, цацрагийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад ажил үүргүүдийг хариуцан ажиллацгааж байна.<br>ЭМТҮЧАБА, эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасаг хамтран эмнэлзүйн 14 тасгийн эмнэлгийн тоног | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмжийн бүртгэл, техник ашиглалтын паспорт хөтлөлтөнд хяналт үнэлгээг хяналтын хуудсаар хийж, 2025 оны 06 сард зохион байгууллаа.<br>Хүүхдийн эмнэлэг нийт 165 техник ашиглалтын паспорт хөтлөж байна. Үүнд:<br>• Хүүхдийн хүлээн авах яаралтай тусламжийн тасаг-14<br>• Хүүхдийн амьсгалын тасаг-8<br>• Хүүхдийн дотрын тасаг-10<br>• Хүүхдийн чих хамар хоолойн тасаг-5<br>• Хүүхдийн мэс заслын тасаг-25<br>• Хүүхдийн эмгэг нярайн тасаг-61<br>• Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг-42<br>• Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг нийт 253 техник ашиглалтын паспорт хөтлөж байна.<br>• Хүлээн авах яаралтай тусламж-50<br>• Эмэгтэйчүүдийн тасаг-27<br>• Дутуу тээлтийн тасаг-15 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Жирэмсний эмгэг эмчлэх тасаг-16<br>• Төрсний дараах тасаг-8<br>• Төрөх тасаг-28<br>• Эрүүл нярайн тасаг-45<br>• Нэгдсэн мэс заслын тасаг- 64<br>Эмийн аюулгүй байдлыг хангахаар эмзүйн албатай хамтран эмийн аюулгүй байдлын хяналтын хуудсаар эмнэлзүйн 16 тасагт хийж, мэргэжил аргазүйн зөвөлгөө өгч ажилласан байна. ЭМС-ын 2023.06.05-ны “Журам шинэчлэн батлах тухай” А/197-р тушаалын “Хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн 3 дахь жагсаалт”-ын дагуу тасгуудын эм тарианы жагсаалтыг шинэчлэн гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна. ЭМС-ын 2023.02.27-ны А/67 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу эмийн гаж нөлөөг бүртгэж, мэдээлж, үнэлж, тайлагнаж, тухай бүрт бүртгэл үүсгэн ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын дотоод хяналт сайжирсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн ажилтан бүр ижил мэргэжилтний үнэлгээ хийж, өөрсдийн үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна.<br>ЭМД-ын сангаас өвчний түүхийн бичилттэй холбоотой хасагдалт буурч байна.<br><br>**ҮР ДҮН:** Төвийн Ерөнхий захирлын 2023 оны А/126 дугаар “Жагсаалт батлах тухай” тушаалаар MNS стандарт 255, оношлогоо, эмчилгээний удирдамж 67, алба тасаг нэгжүүдийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг баталсан. Ерөнхий захирлын 2021 оны “Хүүхдийн болон Эх барихын эмнэлгийн үйл ажиллагааны журам” А/206 дугаар тушаалуудыг тус тус мөрдөн ажиллаж байна. | |
| 79 | **БСТ 6.1.2.**<br>Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн орлого, зарлага, устгалын бүртгэлийн хяналт, хэрэглээний хяналтын тогтолцоог бүрдүүлнэ. | ЭМДСангийн санхүүжилт | *Хяналтын тогтолцооны хэрэгжилтийн хувь* | 96 хувьд хүргэж ажилласан. | 98 хувьд хүргэж ажиллана. | Мансууруулах сэтгэц нөлөөт эмийг орлогыг хүлээн авч дэвтэрт тэмдэглэл хөтлөдөг.Тасагт Эмчилгээ эрхэлсэн дэд захирлаар батлуулж тасгийн эрхлэгчээр гарын үсэг зуруулан олголт хийж орлого зарлагын дэвтэр хөтөлдөг. ЭЭХХЗГ болон хар тамхитай тэмцэх газар албан бичиг явуулж устгах талаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдэгдсэн ЭЭХЗГ -аас байцаагч Б.Оюунхишиг ирж баталгаажуулан ,2025 оны 7 сарын 21 өдөр дүгнэлт ирсэн. 2025 оны 8 сарын 11 өдрийн А/38 тоот тушаал гарсан.2025 оны 8 сарын 14 өдөр Хар тамхитай тэмцэх газрын байцаагч Батцэцэг нарын 2 ажилтан ирж ерөнхий захирлын тушаалаар батлагдсан комис оролцон жагсаалтанд заасан хугацаа дууссан мансууруулах сэтгэц нөлөөт эм ,эмийн туншилыг заавын дагуу устгасан.<br><br>**ҮР ДҮН:** Тасгуудын хэрэглэсэн Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн 1493 хэрэглээг хянаж мэдээлэл өгсөн | |
| 80 | **БСТ 6.1.3.**<br>Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЭМДСангийн санхүүжилт | *Сэргийлсэн хариу арга хэмжээний хэрэгжилтийн хувь* | 96 хувьтай хэрэгжүүлсэн. | 98 хувьд хүргэж ажиллана. | - Эмийн гаж нөлөөгөөр шинэ ажилтан чиглүүлэх сургалт хийсэн 13 хүн хамрагдсан.<br>- Хүүхдийн амьсгалын эрхтний эмгэг судлалын тасагт Курантил,Энтерол, Эмийн буруу хэрэглээнээс үүсэх, Эмийн гаж нөлөө гэж юу вэ сэдвээр 32 үйлчлүүлэгч нар мэдээлэл өгсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Том хүний дотрын тасагт даралт бууруулах, зүрх судас, өвчин намдаах, хоол боловсруулах эмийн хэрэглээний талаар эмийн гаж нөлөө гэж юу вэ сэдвээр 21 үйлчлүүлэгч нар мэдээлэл өгсөн.<br><br>**ҮР ДҮН:** Эмийн гаж нөлөөнөөс сэргийлэх сургалтад 66 хүн хамрагдаж, төвийн хэмжээнд эмийн гаж нөлөө бүртгэгдээгүй. | |
| 81 | **БСТ 6.1.4.**<br>Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ. | ЭМДСангийн санхүүжилт | *Сургалтын тоо* | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт 90 хувьтай хэрэгжсэн. | 95 хувьд хүргэж ажиллана. | - Хүүхдийн амьсгалын эрхтэний эмгэг судлалын тасагт Курантил, Энтерол, Эмийн буруу хэрэглээнээс үүсэх, Эмийн гаж нөлөө гэж юу вэ сэдэвээр 32 үйлчлүүлэгч нар мэдээлэл өгсөн.<br>- Том хүний дотрын тасагт эмийн зохистой хэрэглээ даралт бууруулах, зүрх судас, өвчин намдаах, хоол боловсруулах,эмийн гаж нөлөө, өвчин намдаах эмийн хэрэглээний талаар 21 үйлчлүүлэгч нар мэдээлэл өгсөн.<br>- 2025.04.15-ны Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн эмч нарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | яриан дээр нийт 45 эмчид мэдээлэл өгсөн.<br>- 2025.04.15-ны Сувилахуйн албаны яриан дээр нийт 48 сувилагч нарт мэдээлэл өгсөн.<br>- 2025.10.05 ны Хүүхдийн эмнэлгийн эмч нарын яриан дээр нийт 35 эмч нарт мэдээлэл өгсөн | |
| 82 | **БСТ 6.1.5.** Амбулаторийн эмч нарыг жорын маягтаар хангах, цахим болон маягтын жор бичилтийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлнэ. | ЭМДСангийн санхүүжилт | *Хяналт тогтолцооны хэрэгжилтийн хувь, тайлан* | Жор бичилтийн хяналт 90 хувьтай хэрэгжсэн. | 95 хувьд хүргэж ажиллана. | - Эмийн жор бичилтийг мөрдүүлэх, жороор эм олголтыг хэвшүүлэх эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмч эмийн мэргэжилтэн иргэний хоорондын холбоог сайжруулах хэлэлцүүлэг хийсэн.<br>- Эмнэлгийн дотор байдаг 2 эмийн сангаас 4 сард нийт 568 эмийн жор 18 асуумжаар үзсэн.<br><br>**ҮР ДҮН:** Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор 66 үйлчлүүлэгч, 128 эмч, сувилагч нарт сургалт, мэдээлэл хүргэсэн. | 100% |
| 83 | **БСТ 6.1.6.** “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | ЭМДСангийн санхүүжилт | *Төлөвлөгөөний тайлан, хэрэгжилтийн хувь* | Арга хэмжээ 90 хувьтай хэрэгжсэн. | 90 хувиас дээш хэрэгжүүлнэ. | Харшлын шалтгаант амьсгалын замын архаг өвчнүүдийн тархалтын талаар мэдээллийг төвийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим хуудас дээр нийт 35 удаа мэдээлэл байршуулсан. Харшлаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хэвтэн эмчлүүлэгч болон амбулаториор үйлчлүүлэгч 32610 иргэнд харшлаас урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл хүргэсэн.<br><br>**ҮР ДҮН:** Хүүхдийн харшил судлалын 6 сарын төрөлжсөн мэргэшлийн сургалтад хүүхдийн эмч Б.Ганчимэгийг сургаж, төвийн цахим хуудас дээр нийт 35 удаа мэдээлэл байршуулан амбулаториор үйлчлүүлсэн 32,610 иргэнд харшлаас урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл хүргэсэн. | |
| **СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО ДОЛОО:**<br>Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлнэ. | | | | | | | |
| **Зорилт 7.1: Төвийн үйл ажиллагааны хэрэгцээнд тулгуурлан төсвийг төлөвлөж, үр ашигтай зөв зарцуулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангана.** | | | | | | | |
| 84 | **БСТ 7.1.1.**<br>Хууль, эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж, боломжит орлогын үүсвэрээр төсвийг нэмэгдүүлнэ. | ЭМДСангийн санхүүжилт | *Гүйцэтгэлийн санхүүжилтийн хувь* | Төсвийг 80 хувьд хүргэж ажилласан. | 100 хувьд хүргэж ажиллана. | 2025 онд гүйцэтгэлийн санхүүжилтээр хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг 26,722 иргэнд, амбулаторийн тусламж үйлчилгээг 158,286 иргэнд, яаралтай тусламж үйлчилгээг 71,155 иргэнд тус тус үзүүлэн ажилласан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **ҮР ДҮН:** Эрүүл мэндийн даатгалын сангаас энэ оны эхний 11 сарын гүйцэтгэлийн санхүүжилтээр нийт тусламж үйлчилгээний зардал болох 27,307,991,586 төгрөгийг нэхэмжилсэн. | |
| 85 | **БСТ 7.1.3.**<br>ЭМД-аас санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | ЭМДСангийн санхүүжилт | *Нэмэгдүүлсэн оношийн хамааралтай бүлгийн тоо* | Тусламж үйлчилгээний нэр төрөл 80 хувь байсан. | Тусламж үйлчилгээний нэр төрлийн тоог 100 хувьд хүргэнэ. | ЭМДЕГ-т 73 ОХБ.н жагсаалтыг хүргүүлэн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх санал өгсөнөөс тус эмнэлэг дээр хяналт хийн 53 ОХБ.дээр 2025 онд нэмэлт гэрээлэлт хийн санхүүжүүлэхээр болсон Эмэгтэйчүүдийн хавдар, хими эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээний 8 ОХБ-ээр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ хийж хяналтын шатанд явж байна Хүүхдийн яаралтай тусламж, үйлчилгээгээр (62,945) 1,209,892,466 төгрөг,<br>Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээгээр (16,123) 10,828,891,803 төгрөг,<br>Хүүхдийн амбулаторийн тусламж үйлчилгээгээр (79,748) 1,380,591,855 төгрөг,<br>Хүүхдэд хийгдсэн ходоод, улаан хоолойн дурангийн оношилгоогоор (23) 1,840,000 төгрөг, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүүхдэд хийгдсэн мэс заслын дараах боолт, ажилбараар (450) 9,667,283 төгрөг, Эдийн шинжилгээгээр (56) 3,875,000 төгрөгийн санхүүжилт тус тус бүрдүүлэн ажилласан байна.<br><br>**ҮР ДҮН:** Төвийн тусламж, үйлчилгээний төрөл нэмэгдэж, 2025 онд 53 ОХБ-ийг нэмэлт гэрээлэлт хийж, санхүүжүүлэхээр болсон | |
| 86 | **БСТ 7.1.3.** ЭМДҮЗ-ийн тогтоол, шалгуур үзүүлэлтийн талаар хасагдалгүй ажиллах зөвлөмжийг тасаг нэгжид сургалт зохион байгуулна. | ЭМДСангийн санхүүжилт | Сургалт хийсэн тоо | Нийт 105 удаа сургалт зохион байгуулсан. | Нийт 105-аас дээш удаа сургалт зохион байгуулна. | ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 сарын 23-ны өдрийн 04 дугаар тогтоолд орсон нэмэлт өөрчлөлтийн тухай сургалтыг эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг, хүүхдийн эмнэлэг, поликлиникийн тасгийн эмч, сувилагч нарт 125 удаагийн сургалтыг орж, эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэл, гүйцэтгэлийн шалгуур, цахим хасагдал, эмч байцаагчийн хасагдлын шалтгааныг нэг бүрчлэн гаргаж алдааг давтахгүй ажиллах заавар зөвөлгөөг тухай бүрт өгч өвчний түүх болон амбулаторийн үзлэгийн баталгаажуулалтад хяналтыг тасралтгүй хийж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **ҮР ДҮН:** ЭМД-ын шалгуур үзүүлэлтийн талаар эмч, сувилагч нарт **125 удаагийн** сургалтыг орж, цахим хасагдал 49%, эмч байцаагчийн хасагдал 51%-иар буурсан үзүүлэлтэй байна. | |
| СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО НАЙМ:<br>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангана. | | | | | | | |
| Зорилт 8.1: Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана. | | | | | | | |
| 87 | **БСТ 8.3.2, 8.3.4.**<br>Гарын эрүүл ахуйг сайжруулах, сахилтын түвшинг нэмэгдүүлнэ. | ЭМДСангийн санхүүжилт | Үнэлгээний хувь, үр дүнгийн тайлан | Гарын эрүүл ахуйг сайжруулах түвшин 95 хувьд хүрсэн. | 100 хувьд хүргэж үр дүнг тооцож ажиллана. | Төвийн ерөнхий захирлын 2024 оны А/72 тоот тушаалаар Хүүхдийн эмнэлэг болон Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгийн тасаг бүрийн эрхлэгч, их эмч, ахлах сувилагч нийт 62 хүний бүрэлдэхүүнтэй Халдварын сэргийлэлт, хяналтын орон тооны бус багийг томилсон. ЭТҮХХ-аас сэргийлэх чиглэлийн хүрээнд ЭМС-ын 2017 оны А/505, 2019 оны А/537, А/539 дүгээр тушаалыг төвийн ажилчдад сурталчлах, хэрэгжилтийг бүрэн хангуулах зорилгоор 10 сэдэв бүхий сургалтыг “Төвийн 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-нд тусган батлуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Гар угаах, халдваргүйжүүлэх заавар<br>- Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ<br>- Хог хаягдлын менежмент сэдвүүдээр сургалт зохион байгуулаад байна.<br>ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Гар угаах, халдваргүйжүүлэх заавар”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллаж байна. Үүнд:<br>- Байгууллагын ажилчдын гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэгийг шалгах 10 асуулт бүхий сорил боловсруулсан.<br>- Алба, тасгийн мэргэжилтнүүдийг гар угаах, халдваргүйжүүлэх ур чадвар, мэдлэгийг сайжруулах ажлын байрны сургалтын графикчилсан төлөвлөгөөг боловсруулсан.<br>- Гар угаах, халдваргүйжүүлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дараах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгуур хуудсуудыг боловсруулсан. Үүнд:<br>▪ Ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг үнэлэх шалгуур<br>▪ Үйлчлүүлэгчийн өрөөний гар угаах халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдлыг үнэлэх шалгуур<br>- ХСХТА-ны 7 ариутгагч, 4 угаагчид “Гар угаах, халдваргүйжүүлэх заавар” сэдвээр ажлын байрны сургалт зохион байгуулж сургалтын өмнө болон дараа мэдлэг шалгах сорилыг авч үнэлгээжүүлэхэд бүх ажилчидын мэдлэг 10-50%-иар дээшилсэн байна.<br><br>**ҮР ДҮН:** Төвийн 80 эмч, 125 эх баригч, сувилагч нарын гар угаах, халдваргүйжүүлэх чадварыг үнэлэхэд бүгд 89-95% үнэлэгдсэн. | |
| 88 | **БСТ 8.3.2, 8.3.4.** Халдварт өвчний хяналт, үнэлгээ, ББТ-ийн тандалт судалгааг тогтмол хийнэ. | - | Тандалт судалгааны тоо Үнэлгээ, тайлан | Тандалт судалгааг 95 хувьд хүргэсэн. | 100 хувьд хүргэж үр дүнг тооцож ажиллана. | 2025 оны I улиралд төвийн нийт 367 ажилчдын гепатит В вирусийн вакцинд хамрагдалтын судалгааг боловсруулан мэдээллийн сан үүсгэсэн. Энэхүү | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлийн санд ажилчдын ерөнхий мэдээлэл болон “Элэгний В вирус илэрч байсан эсэх, вакцинд хамрагдсан он, хэдэн тунд хийлгэсэн, дархлаа тогтоц тодорхойлуулж байсан эсэх мэдээллийг бүрдүүлсэн. Нийт 136 ажилчдын цусны сорьцыг цуглуулж БНХАУ-ын Autobio Anti-HBs урвалжийг ашиглан Autolumo аппаратаар chemiluminescence immunoassay (CLIA) аргыг ашиглан HBs-ийн эсрэгбиеийн титрийг тодорхойлоход нийт 110 ажилтанд дархлаа тогтоц үүссэн байна.<br>2025 оны II улиралд дээрх судалгаанд боловсруулалт хийн гепатит В вирусын вакцин хийлгээгүй, дархлаа тогтоц үүсээгүй нийт 317 ажилчдыг сонгон Hepatitis B vaccine (rDNA) (энэтхэг улсад үйлдвэрлэсэн, хүчинтэй хугацаа: 2026.04 сар) вакциныг нийт 55 хүнд хийж дархлаажуулалтын цахим бүртгэлд бүртгэсэн.<br>Ажилчдын улаанбурхан өвчний вакцинжуулалтыг судалгааг III сард хийхэд нийт 425 ажилчдын 195 ажилтан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нь улаанбурханы дархлаажуулалтад хамрагдсан, байгалийн дархлаа тогтсон байна. Үүнээс нэмэлт дархлаажуулалтад хамрагдсан 167, асуумж судалгаагаар өвдсөн 27, дархлаажуулагдсан 45 байсан. Нийт 52 ажилчдад “Measles and rubella vaccine” (энэтхэг улсад үйлдвэрлэсэн, хүчинтэй хугацаа: 2025.07 сар) вакциныг хийж дархлаажуулсан.<br>“Эрүүл мэндийн ажилтны үзлэг шинжилгээ, дархлаажуулалт (ЭНЭҮТ-II)” гэсэн нийт 33 асуумж бүхий судалгааг google forms ашиглан нийт 132 ажилчдаас мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийж байна.<br>Лабораторийн эмч нартай хамтарсан харилцан мэдээлэл солилцох телеграмм группээр нийт 8 үйлчлүүлэгчийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажиллаж байна.<br>Улаанбурханы дэгдэлтийн үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ:<br>- Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх болон | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэгдсэн тохиолдлын үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Тохиолдол удирдлагын тогтолцооны баг бүрэлдэхүүний хурлыг 2 удаа зохион байгуулж ажилласан.<br>- Улаанбурхан өвчний тандалт хариу арга хэмжээг сайжруулах чиглэлээр ХӨСҮТ-ийн мэргэжилтэнгүүд 2 удаа (III/25, IV/19-нд) зөвлөн туслах дэмжлэгт хяналтыг ажлын байранд хийж 16 чиглэлээр 21 зөвлөмжийг өгсөн.<br>- Хүүхдийн болон эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгт III/24-өөс XII/02-нд бүртгэгдсэн улаанбурханы сэжигтэй буюу цочмог халууралт, тууралтат хам шинжийн сэжигтэй нийт 267 тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлж, ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид цус, хамар-залгиур, ам-залгиурын сорьцыг шинжилгээнд хүргүүлсэн.<br>- Лабораторийн шинжилгээгээр батлагдсан 117 тохиолдлыг үйлчлүүлэгчийг шилжүүлэх журмын дагуу урьдчилан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлж ХӨСҮТ-д шилжүүлсэн. Үгүйсгэгдсэн үйлчлүүлэгчдийг энгийн тасагт шилжүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлсэн.<br>- Лабораторийн шинжилгээгээр батлагдсан тохиолдол болон түүний гэр бүлийн хавьтлын судалгааны мэдээллийг илтгэх хуудас, хүснэгтэн хэлбэрээр ХӨСҮТ-ийн мэргэжилтэнгүүдэд тухай бүр мэдээлж байна. Мөн Google sheet ашиглан долоо хоног бүр мэдээлэл солилцон ажиллаж байна.<br>- Хүүхдийн эмнэлэг, Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг, амбулаторийн тасагт хэвтэн эмчлүүлэгчийн улаан бурханы дархлаажуулалтад хамрагдсан байдал, улаанбурхан өвчнөөр өвдсөн эсэхийг тандах асуумжийг нийт 4536 гаруй хэвтэн эмчлүүлэгчдээс авч цахимд бүртгэсэн.<br>- Эх барих эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эмнэлгийн хүлээн авахын цахим бүртгэгч үйлчлүүлэгч бүрт амны хаалт зүүж, бөгнөрөл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үүсгэхгүй байхыг тогтмол сануулан анхааруулж ажиллаж байна. Амбулаторийн хэсэгт хөтөч сувилагч үйлчлүүлэгч бүрт улаанбурханаас сэргийлэх зааварчилгаа өгч, амны хаалт зүүж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахыг зөвлөн, холбогдох үзлэгийн өрөөг чиглүүлэн ажиллаж байна. Сурталчилгааны материалыг зөвлөх клиник, амбулатори, хүлээн авахын цахим бүртгэл, эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг, хүүхдийн эмнэлгийн тасгийн үйчлүүлэгчид нийт 488 ширхэгийг тараан мэдээллээр хангасан. Хүүхдийн болон эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийг өдөр бүр бүтэн биеийн үзлэг хийж тууралтат хам шинжийн сэжигтэй нийт 153 тохиолдлыг илрүүлэн тусгаарлан хяналтад авсан. Сэжигтэй тохиолдлын ойрын хавьтлын судалгааг тухай бүр хийж нийт 2191 орчим хавьтлыг бүртгэлжүүлсэн. АУ-ны доктор, ХӨСҮТ-ийн М.Оюунгэрэл мэргэжилтэнг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урьж “Улаанбурхан өвчний эмнэлзүй, оношлогоо ялган оношлогоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн.<br>Бактериологийн лабораторид антибиограммыг боловсруулан холбогдох албадууд, төвийн эмч, мэргэжилтнүүдэд мэдээллэн ажиллаж байгаа бөгөөд MRSA, ESBL гэх мэт аюултай, анхаарал татсан шинжилгээний хариуг халдвар судлаачид мэдээллэн ажиллаж байна. Бактериологийн лабораторид антибиограммыг боловсруулан холбогдох албадууд, төвийн эмч, мэргэжилтнүүдэд мэдээллэн ажиллаж байгаа бөгөөд MRSA, ESBL гэх мэт аюултай, анхаарал татсан шинжилгээний хариуг халдвар судлаачид мэдээллэн ажиллаж байна.<br><br>**ҮР ДҮН:** 2025 оны I улиралд төвийн нийт 367 ажилчдын гепатит В вирусийн вакцинд хамрагдалтын судалгааг авч, HBs-ийн эсрэгбиеийн титрийг тодорхойлоход нийт 110 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтанд дархлаа тогтоц үүссэн тул 2025 оны II улиралд В вирусын вакцин хийлгээгүй, дархлаа тогтоц үүсээгүй нийт 317 ажилчдыг сонгон Hepatitis B vaccine (rDNA) вакциныг нийт 55 хүнд хийж дархлаажуулалтын цахим бүртгэлд бүртгэсэн. Ажилчдын улаанбурхан өвчний вакцинжуулалтыг судалгааг 03 сард хийхэд нийт 425 ажилчдын 195 ажилтан нь улаанбурханы дархлаажуулалтад хамрагдсан, байгалийн дархлаа тогтсон тул нэмэлт дархлаажуулалтад 52 ажилчдад “Measles and rubella vaccine” хийсэн. Резидент эмч нарыг шинжилгээнд хамруулан улаан бурхан, томуугийн вакцинд хамруулсан. | |
| Зорилт 8.2: Төвийн материаллаг баазыг бэхжүүлж, автомашинуудыг дулаан гражаар, эргэлтийн болон үндсэн хөрөнгийг стандартын дагуу хадгалах агуулахаар хангах ажлыг зохион байгуулна. | | | | | | | |
| 89 | **БСТ 8.2.1.** Түргэн тусламж, үйлчилгээ, ажилтны автобус, автомашины, засвар үйлчилгээг тогтмолжуулж, аюулгүй байдлыг хангана. | 30.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Төлөвлөсөн арга хэмжээ 90% хэрэгжсэн. | Төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна. | Ажилчдын 2 автобус, түргэн тусламжийн үйлчилгээний 6 ниссан урбан, 1 логан суудлын автомашиныг “МОННИС МОТОРС” ХХК-ийн гэрээний дагуу 9,559,700 төгрөгний төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийж байна. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Тос тосол сольсон<br>-Наклад сольсон<br>-Зуны дугуй<br>-Амартизатор<br>-5014 Аккумлятор-2ш<br>-5017 Маяк<br>- Явах эд ангийн оношлогоо<br>Жолоочийн хариуцлагын болон тээврийн хэрэгслийн даатгалд бүрэн хамруулсан | |
| Зорилт 8.3: Тусламж, үйлчилгээний технологи, чанарыг үнэлүүлж, магадлан итгэмжлэл авна. | | | | | | | |
| 90 | **БСТ 8.3.2.**<br>Үйлчлүүлэгч төвтэй (цаг товлох, мэдээллийн лавлах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоо) үйлчилгээг төлөвшүүлнэ. | ЭМДСангийн санхүүжилт | *Үйлчлүүлэгчдийн тоо* | Сар үйлчлүүлсэн хүний тоо 10000 хүрсэн байна. | Үйлчлүүлэх хүний тоог 12000 хүргэж ажиллана. | Орчин үеийн дэвшилтэт технологи One call системийг нэвтрүүлсэн. Цаг авсан үйлчлүүлэгч цагтаа ирэх эсэхийг цахим систем ашиглан тодруулдаг болсон. 12870 иргэнд уг системийг ашиглан үйлчилгээ үзүүлсэн.<br><br>**ҮР ДҮН:** One call системийг нэвтрүүлэн **12870 иргэнд** цаг товлох үйлчилгээг үзүүлсэн. | 100% |
| 91 | **БСТ 8.3.3.**<br>UpToDate платформыг ашигладаг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг нэмэгдүүлнэ. | Олон улсын байгууллага, ЭМДСангийн санхүүжилт | UpToDate платформыг ашигладаг эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | UpToDate платформыг ашигладаг эмч мэргэжилтний тоо 35 хувьтай байна. | UpToDate CME оноог бүрдүүлсэн байна. | UpToDate платформыг ашигладаг 75 эмч, 56 эмнэлгийн мэргэжилтнүүд байна. | 100% |
| 92 | **БСТ 8.3.5.**<br>Төвийн үйл ажиллагааг магадлан итгэмжлүүлнэ. | | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/554 тоот тушаал | 2 жил | 5 жил | 2025 оны 11 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд магадлан итгэмжлэлийн 7 шинжээчийн бүрэлдэхүүнтэй баг төвийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн.<br><br>**ҮР ДҮН:** Шинжээчдийн өгсөн зөвлөмж, үнэлгээгээр амжилттай үнэлэгдсэн. | |
| Зорилт 8.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх болон үйл ажиллагааны хэвийн нөхцөлөөр хангаж ажиллана. | | | | | | | |
| 93 | **БСТ 1,2,3,4,5,6,7,8.** Төвийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Батлагдсан стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Стратегийн 8 ерөнхий, 8 үндсэн чиглэл, 67 зорилт бүхий стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 100% | Стратеги төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлж ажиллана. | Төвийн дунд хугацаа /2023-2026 оны/-ны стратеги төлөвлөгөөг Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 13.7, 16.16, 17.4, 22.1, 23.1, 24.1, 32.1, 32.2; Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 9.2, 9.3, 18.1.1, 18.1.2.4, 18.1.3, 18.2, 23.1; Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1.1, 13.1.2; “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2.1, 2.2.11, 2.2.16, 2.2.20, 2.2.22, 2.2.25, 2.2.27, 2.2.28, 2.2.29, 2.2.30, 2.2.36, 2.2.37, 2.2.38, 2.2.39; Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1.1.3, 2.1, 2.1.6, 2.1.8, 2.1.1.3, 2.1.7, 2.1.4.2, 2.1.4.4 дэх заалтуудыг үндэслэн эх, ураг, нярай, хүүхэд, эмэгтэйчүүдэд үзүүлэх эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | анагаахын тусламж үйлчилгээг дэлхийн жишигт ойртуулах, эх ургийн анагаах ухааныг хөгжүүлэх, эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэх, өсвөр үеийн эрүүл мэндийг сайжруулах асуудлуудыг шийдвэрлэхээр шинэчлэн боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Энэхүү стратеги төлөвлөгөөнд төвийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, зорилго, зорилтуудыг шинэчлэн тодорхойлж, салбарын бодлоготой уялдуулан, байгууллагын хэтийн хөгжлийг дэмжсэн арга хэмжээнүүдийг хэрэгжих боломж, нөөцийг тооцон боловсруулсан бөгөөд стратеги төлөвлөгөө нь Алсын хараа, Эрхэм зорилго, стратегийн 8 ерөнхий чиг үүрэг, 16 үндсэн чиг үүрэг, 65 дэд чиг үүргээс бүрдэнэ. Тус төв нь 660 ор бүхий лавлагаа шатлалын 2 эмнэлэг/хүүхдийн эмнэлэг, эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэг/ төрөлжсөн мэргэжлийн 24 тасаг, 2 зөвлөх поликлиник, дэмжих | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний 11 алба, 450 орон тоотойгоор эх, эмэгтэйчүүд, ураг-нярай хүүхдэд төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна. | |
| 94 | **БСТ 8.1.1.** Төвийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр тодотгож хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 2022.11.10-нд 7 үйл ажиллагаа бүхий 75 арга хэмжээ төлөвлөж нийт 9 удаа тодотгол хийж, 100 хувийн хэрэгжилттэй ажилласан. | Төвийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна. | Төвийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээр батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомж, удирдлагын баримт бичиг, 2025 оны ЭМС-ын 01 тоот, 08 тоот албан даалгаварууд, ЭМС-ын А/249 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд 2025 оны 01 сарын 10-ны өдөр Халдварт өвчин “Томуу, томуу төст өвчин, Улаанбурхан өвчин, Менингококт халдварын дэгдэлт”-ийн үеийн бэлэн байдлыг хангах, 2025 оны 06 сарын 26-ны өдөр “Улаан бурхан өвчний тархалтаас сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлыг ханган ажиллах, дархлаажуулалтыг зохион байгуулах", 2025 оны 10 сарын 20-ны өдөр "Зуд болон томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээ авах" төлөвлөгөөг Төвийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, гишүүдийг дахин шинэчилж, бэлэн байдлыг ханган ажиллалаа. | |
| 95 | **БСТ 8.1.2.** Гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын үед шаардагдах нөөцийг бүрдүүлж ажиллана. | 40.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Бүрдүүлсэн нөөцийн тоо хэмжээ | 6.2 тэрбум төгрөгний эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнсний, цэвэрлэгээний материалын, түлш шатахууны 2-4 сарын нөөцтэй. | 1-3 сарын хэрэглээний нөөцийг бүрдүүлсэн байна. | Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж шаардлагатай хөрөнгө, материалын 2 сарын нөөцийг сэлгэлтээр тогтмол бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд эм, эмнэлгийн хэрэгслийн 2.83 тэрбум төгрөгний 2 сарын, хоол хүнсний материалын 41.5 сая төгрөгний 2 сарын, цэвэрлэгээний материалын 45.8 сая төгрөгний 2 сарын , түлш шатахууны 10.9 сая төгрөгний 2 сарын нөөцтэй байна. | 100% |
| 96 | **БСТ 8.1.1, 8.1.2.** Төлөвлөлтийн Удирдлагын Тогтолцооны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | ЭМДСангийн санхүүжилт | ТУТ-ын төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь | ТУТ-ын төлөвлөгөөний гүйцэтгэл 90% байна. | ТУТ ын төлөвлөгөөний гүйцэтгэлийг 90%-аас доошгүй хэрэгжүүлнэ. | ТУТ-ын тодотголыг цаг хугацаанд хийж нийт 13 удаагийн тодотгол хийснээс 2025 онд 3 удаагийн дараах тодотголыг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомж, удирдлагын баримт бичиг, 2025 оны ЭМС-ын 01 тоот, 08 тоот албан даалгаварууд, ЭМС-ын А/249 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд 2025 оны 01 сарын 10-ны өдөр Халдварт өвчин “Томуу, томуу төст өвчин, Улаанбурхан өвчин, Менингококт халдварын дэгдэлт”-ийн үеийн бэлэн байдлыг хангах, 2025 оны 06 сарын 26-ны өдөр “Улаан бурхан өвчний тархалтаас сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах, дархлаажуулалтыг зохион байгуулах”, 2025 оны 10 сарын 20-ны өдөр “Зуд болон томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээ авах” төлөвлөгөөг Төвийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, гишүүдийг дахин шинэчилж, бэлэн байдлыг хангаж ажиллалаа | |
| 97 | **БСТ 8.2.3.** Хоол үйлдвэрлэлийн тасгийн тохижилтийг | 30.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Төлөвлөсөн арга хэмжээний | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 85% | 100 хувь хэрэгжүүлж ажиллана. | Хоол үйлдвэрлэлийн тасгийн халуун цех, 1,2 дугаар хоолны тогоо, мах бэлтгэл, талх, нарийн боовны цехийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | стандартын дагуу зохион байгуулна. | | хэрэгжилтийн хувь | | | хэсгийн 162 м,кв таазыг 17,867,740 төгрөгөөр 100 хувь стандартад нийцсэн төмөр дүүжин тааз, Мөн 5 цэгт ус алдаж цоорсон хэрэглээний халуун усны шугмын ф-50 төмөр хоолойг ппр ф-64 тэй 8 м шугамаар холбож босоо шугамын өгөх буцах 4 хоолойг ф-64-өөс ф-25 болгон хэрэглээнд тааруулан шилжүүлэг хийсэн. | |
| 98 | Төвийн бохирын системийн шинэчлэлийг үе шаттайгаар эхлүүлнэ. | 9.0 (ЭМДСангийн санхүүжилт) | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг 100 хувьд хүргэнэ. | Төвийн бохирын хэрэглээг Буян-Ухаа 2 хорооллын урдуур орж ирсэн улсын ф-400 мм шугамын худагт шууд холбох УСУГ-ын Техникийн нөхцөл олгох комиссын 2025 оны 10 сарын 24 өдрийн шийдвэрийн 725/25 тоот техникийн нөхцөл авсан бөгөөд бохирын системийг шинэчлэх төсвийг худалдан авах төлөвлөгөөнд тусгасан. | 85% |
| Нийт хувь-97,6 | | | | | | | |

Төлөвлөгөөг хянасан: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД ......................... /Ж.ЧИНБҮРЭН/

Тамга ............................
(огноо)

Төлөвлөгөө тайлагнасан: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ ......................... /А.ЭРДЭНЭТУЯА/

Тэмдэг .............................. (огноо

Тайлан нэгтгэсэн:

СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ Ц.ТУЛГА